

УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны санал, ҮАГ-ын төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

## САНГИЙН ХӨРӨНГӨ ӨССӨН Ч АЖИЛГҮЙДЭЛ БОДИТОЙ БУУРААГҮЙ БАЙНА



**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн**

**Тайланг бэлтгэсэн:**

**ҮАГ-ын Гүйцэтгэлийн  
аудитын газар**

*Захирал*

*Д.Ганбилэг*

*Аудитын менежер*

*Х.Баярмаа*

*Ахлах аудитор*

*С.Сэрчхорол*

*Шинжээч Д.Баттулга*

*Б.Болормаа*

*Р.Цолмон*

**2010 оны 7 дугаар сар**

***Уг тайланг ҮАГ-ын  
вэб сайт-аас үзнэ үү:***

**[www.mnao.mn](http://www.mnao.mn)**

*Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах зүйл  
байвал 261885, 263755 дугаарын  
утас, 323266 дугаарын  
факсаар харилцана уу.*

**ХАЯГ:**

*Үндэсний аудитын газар  
Засгийн газрын 4 дүгээр байр,  
Бага тойруу-6, Улаанбаатар-46  
15160  
Монгол Улс*

<b>Товчилсон үгсийн жагсаалт</b>	2
<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</b>	3
<b>Бүлэг 1 Сангийн орлого бүрэн төвлөрөөгүй байна</b>	
• Оршил	4
• ХЭДС-гийн орлогын дийлэнх хувийг гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр эзэлж байна	4
• Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхдөө хуулийг чанд мөрдөхгүй байна	5
• Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний ажлын байрны төлбөрийг дутуу тооцсон тохиолдол байна	9
• Гадаадын ажиллах хүчний бүртгэлд тавих хяналт хангалтгүй байна	9
• 2009 оны сангийн хөрөнгийн төсөвт хоёр удаа тодотгол хийжээ	10
<b>Бүлэг 2 Сангийн зарцуулалт болон зээлийн ашиглалт хангалтгүй байна</b>	
• Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих явцын хяналт хангалтгүй байна	13
• НХХЯ зарим тендерийг сонгон шалгаруулаагүй байна	20
• Зээл нь ажилгүйдлийг бууруулахад дорвитой нөлөөлж чадахгүй байна	20
• Ажилгүйдлийн судалгаа бодитой бус байна	22
• <b>Дүгнэлт</b>	24
• <b>Холбогдох байгууллагын санал</b>	25
• <b>Зөвлөмж</b>	32

# Товчилсон үг

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЗТБХБЯ	Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яам
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
НХХС	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
ЭБЭХС	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд
ЗТБХБС	Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ГИХАЭГ	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар
АХГГГАХМАТХ	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХЭДТХ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
НДТХ	Нийгмийн даатгалын тухай хууль
ГЭЗБТХ	Гадаадын эрх зүйн байдлын тухай хууль
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ТББ	Төрийн бус байгууллага
БИТ	Бизнес инкубаторын төв
БХДТ	Бизнесийн хөгжлийг дэмжих төв
ССХОБЗА	Сургалт, судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн алба
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
МУИС	Монгол Улсын их сургууль
ХИС	Хүмүүнлэгийн их сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ХЭА	Хөдөлмөр эрхлэлтийн алба

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитыг Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хорооны санал, ҮАГ-аас Монгол Улсын Ерөнхий аудиторт 2010 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

### Аудитын зорилт

ХЭДС-гийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, хуваарилалт зохих журмын дагуу хийгдэж байгаа эсэх;
- Сангийн хөрөнгийн зарцуулалт, олгосон зээлийн ашиглалт үр нөлөөтэй эсэх

### Хамарсан хүрээ

Аудитад НХХЯ, ХХҮГ, аймаг, нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ын ХХҮХ, ХЭДС-гаас жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэх банк, банк бус санхүүгийн байгууллага, тэдгээрийн орон нутаг дахь салбар нэгж, холбогдох байгууллагуудыг түүвэрчилж хамруулав.

### Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- ХЭДС-гийн орлогын бүрдүүлэлтийг түүвэрлэн шалгах;
- Холбогдох эрхийн актыг судлах;
- ХЭДС-гийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой судалгаанд дүн шинжилгээ хийх;
- ХЭДС-гаас бараа, ажил үйлчилгээг ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу худалдан авсан эсэхийг түүвэрлэн шалгах;
- Сангийн яам болон холбогдох бусад байгууллагын ажилтнуудтай ярилцлага хийж, тодруулга авах;
- Гадаадаас авсан ажиллах хүчний судалгааг гаргуулах;

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

# Бүлэг 1

## Сангийн орлого бүрэн төвлөрөөгүй байна

### Оршил

1.1 ХЭДС-гийн орлого улсын төсвийн хөрөнгө<sup>1</sup>, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил үйлчилгээ эрхлүүлсний төлөө төлөх ажлын байрны төлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөр болон бусад эх үүсвэрээс бүрддэг.

1.2 ХЭДС-гийн орлого, зарлагын үзүүлэлтийг сүүлийн таван жилийн байдлаар дараахь хүснэгтээр харууллаа. Үүнд:

		( сая төгрөгөөр)				
Үзүүлэлт / он		2005	2006	2007	2008	2009
Орлого	Ажлын байрны төлбөр	3736.0	6411.7	9664.4	16088.7	12682.4
	Бусад	137.3	108.9	1375.7	134.3	9599.0
Нийт орлого		3873.3	6520.6	11040.0	16223.0	22281.4
Зарлага		3125.8	4250.0	10883.8	15303.6	21494.3

1.3 2005 оныг 2009 онтой харьцуулахад сангийн зарлага 6.9 дахин өсчээ.

### ХЭДС-гийн орлогын дийлэнх хувийг гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр эзэлж байна

1.4 ХЭДС-д 2009 онд 22 281.4 сая төгрөгийн хөрөнгө төвлөрчээ.



1.5 Нийт орлогын 57.0 хувийг гадаад иргэдийн ажлын байрны төлбөр, 40.0 хувийг жижиг зээлийн эргэн төлөлт, үлдсэн хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр эзэлж байна.

1.6 2009 онд жижиг зээлийн эргэн төлөлтийн 9.0 тэрбум төгрөгийг ХЭДС-д төвлөрүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эх үүсвэр болгожээ.

1.7 Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуулиар ХХҮГ-т гадаад иргэдийн ажлын байрны төлбөрт 25000.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө баталж, гүйцэтгэлээр 12 682.4 сая төгрөг төвлөрүүлжээ.

1.8 Монгол Улсад гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах асуудал АХГГГАХМАТХуулийн дагуу зохицуулагддаг ба гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх зам, барилгын ажил болон

<sup>1</sup> ХЭДТХ-ийн 16.1-д улсын төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь төсвийн орлогын 0,3 хувиас доошгүй байна.

бусад үйл ажиллагаа өргөжсөнтэй холбоотойгоор гадаадаас авах ажиллах хүч жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. Үүнийг сүүлийн 10 жилийн байдлаар харуулбал:


Он	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаад иргэний тоо	5626	8075	7532	7250	8221	12577	18504	37507	31041

1.9 2008 онд гадаадаас авсан ажиллах хүчний тоог 2001 оныхтой харьцуулахад 6.7 дахин өссөн бол 2009 онд өмнөх оноос 6 466 хүнээр буурчээ.

1.10 Өнгөрсөн онд гадаадын 31041 (давхардсан тоогоор) иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон ба эдгээр иргэдийн 84.4 хувь БНХАУ, 4.6 хувь ОХУ, 1.9 хувь БНСУ, 1.2 хувь АНУ, үлдсэн хувийг БНСАУ, Япон, Вьетнам болон бусад улс орны иргэд эзэлж байна.

1.11 Гадаадаас авсан ажиллах хүчний дийлэнх хувийг уул уурхай, олборлох үйлдвэр, барилгын салбарт ажиллагсад эзэлж байна.

1.12 Мэргэжлээр нь ангилж үзвэл техникийн ажилтан 16 728, мэргэжилтэн болон туслах ажилтан 13 421, багш 608, бусад мэргэжлийн ажилтан 284-ийг гадаадаас авч ажиллуулжээ.



### Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхдөө хуулийг чанд мөрдөхгүй байна

1.13 АХГГГАХМАТХуулийн 4.1.4-т “эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын нийт ажиллагчдын тоо, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг жил бүр тогтоож, Засгийн газраар батлуулах”, 9.6-д “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журмыг Засгийн газар тогтооно” гэж заасан байна.

1.14 Дээрх хуулийн дагуу Засгийн газар “2009 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай” 59 дүгээр тогтоол гарган Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн 2009 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг салбар болон дүрмийн сан, хөрөнгө оруулалтын хэмжээ, нийт ажиллагчдын тоог үндэслэн баталжээ.

1.15 2009 онд Засгийн газрын 5 удаагийн тогтоолоор 39 аж ахуйн нэгжийн 15 778 гадаадын иргэнд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосноос 10 298 иргэдийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн нь 10.0 тэрбум төгрөг болсон байна.

1.16 Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон иргэдээс 5 650 нь барилга угсралтын ажилд, 4 223 нь автозамын чиглэлд, 4 680 нь газрын тосны хайгуул, судалгааны

ажилд, 640 нь УЦС барихад, 410 нь газрын тос боловсруулах үйлдвэрт, 200 нь төмөр замын чиглэлд тус тус ажиллахаар тогтоожээ.

1.17 Гадаадаас ажиллах хүч оруулж ирэхийн тулд аж ахуйн нэгж, байгууллага аймаг, нийслэлийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй ажиллах хүчний квотыг хангах хэлбэр төдий гэрээ байгуулсан тохиолдол байна. Тухайлбал,

- *“Их үйлсийн эрэлд” ХХК* “Баянмонгол” хорооллын барилгын ажлыг гүйцэтгэхэд гадаадаас ажиллах хүчний зөвшөөрөл авах квотыг өндөр тогтоолгох үүднээс Хөдөлмөрийн төв биржэд бүртгэлтэй ажилгүй 800, Нийслэлийн хөдөлмөрийн газарт бүртгэлтэй 900 хүнийг ажлын байраар хангахаар гэрээ байгуулжээ. Засгийн газар тус компанид БНХАУ-аас 900 хүнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгож, ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн боловч тухайн компани дээрх гэрээний дагуу нэг ч хүн ажилд аваагүй байна.
- Тус компани гадаадаас авах ажиллах хүчийг Засгийн газрын тогтоосон квотоос 488 хүнээр хэтрүүлж, 737.9 сая төгрөгийн ажлын байрны төлбөрийг төлөөгүй байна.

1.18 АХГГАХМАХТХуулийн 7.2.4<sup>1</sup>, 8.2.2<sup>2</sup>, 8.2.6<sup>3</sup> -д заасан нөхцөлийг хангаагүй, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлгүй зарим аж ахуйн нэгжид гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, тэднийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай асуудлыг НХХЯ Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлжээ.

1.19 Засгийн газрын 2001 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 3.11<sup>3</sup>-д заасны дагуу 2009 онд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллагад хэт хавтгайруулан олгосон байна. Тухайлбал,

- *“100 мянган айлын орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд барилгын ажил гүйцэтгэхэд “Азунхуй” ХХК-ийн 200, “Богда холдинг” ХХК-ийн 400, “Гандирс” ХХК-ийн 150, “Задран” ХХК-ийн 500, “Зумбоо” ХХК-ийн 300, “Зунгуо жиэнь жү Монгол” ХХК-ийн 300, Зуншин ХХК-ийн 250, Иншипин ХХК-ийн 80, “Хэм рояал”-ХХК-ийн 400, “Шинэ дөл” ХХК-ийн 150, барилгын чиглэлийн үйлдвэр бариулахаар “Нар урт” ХХК-ийн 345, замын чиглэлээр “Насны зам” ХХК-ийн 340 гадаадын инженер, техникийн ажилтан, ажилчдад Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг олгохдоо тухайн аж ахуйн нэгжийн дүрмийн сан, хөрөнгө оруулалтын хэмжээ, нийт ажилчдын тоог харгалзаагүй бөгөөд гадаадаас авах ажилтны тоог тогтоохдоо холбогдох хууль, журмыг баримтлаагүйгээс сангийн орлогыг 1.6 тэрбум төгрөгөөр бууруулжээ. (Хавсралт № 1)*

1.20 Аж ахуйн нэгж, байгууллагууд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулахдаа улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр, барилга байгууламж барих нэрийн дор хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авч, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдөх хандлага их байгаад яамны зүгээс тодорхой хяналт тавьж чадаагүй

<sup>1</sup> АХГГАХМАТХ-ийн 7.2.4-мэргэжил, боловсролын түвшинг баталсан баримт бичгийг харилцан зөвшөөрөх нөхцөл,

<sup>2</sup> 8.2.2-г аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн нотариатаар батлагдсан хуулбар, гадаадын иргэний мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар, 8.2.6-г хөдөлмөр эрхлүүлэх салбарын яам, агентлагийн тодорхойлолт,

<sup>3</sup>Засгийн газрын 2001 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 3.11<sup>3</sup>-т “Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга, байгууламж барих, байгалийн гамшиг, сүйрлийн хор хөнөөлийг арилгахад шаардагдах ажиллах хүч, мэргэжилтнийг Засгийн газрын шийдвэрийн дагуу гадаадаас авч ажиллуулах тохиолдолд ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө” мэргэжилтнийг Засгийн газрын шийдвэрийн дагуу гадаадаас авч ажиллуулах тохиолдолд ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө”

нь сангийн хөрөнгийн орлогыг бууруулах, ажлын байр шинээр бий болгох, ажилгүйдлийн түвшинг багасгах боломжийг алдаж байна. Энэ нь АХГГАХМАТХуулийн 9.4<sup>4</sup>-т заасан заалттай зөрчилдөж байна.

1.21 Засгийн газрын тогтоолоор хөнгөлөлтөд хамрагдсан 39 аж ахуйн нэгжийн 7 415 иргэнээс 934 нь ГИЭЗБТХ-ийн 23.1<sup>5</sup> дэх заалт, Захиргааны хариуцлагын тухай хуулийн<sup>6</sup> дагуу торгуулийн арга хэмжээ авагдсан бөгөөд оруулж ирсэн гадаадын ажилчдыг өөрийн компанидаа ажиллуулаагүй, төлөвлөсөн төсөл хөтөлбөрөө бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал,

- *Засгийн газрын 2009 оны 158 дугаар тогтоолоор "100 мянган айлын орон сууц" хөтөлбөрийн хүрээнд барилгын ажил гүйцэтгэхэд БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай "Иншифин" ХХК 80 хятад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авч, 40 хүнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлсэн боловч төлөвлөсөн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, оруулж ирсэн 77 ажилчинг "Азийн ирээдүй" ХХК-д албан бусаар шилжүүлэн ажиллуулсан, хасалт хийлгээгүй 11 хүний байрны төлбөрийг бүрэн төлөөгүй;*
- *Энэ тогтоолоор Булган-Үенч-Ховдын чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэгч "Читай" ХХК-ийн 260 гадаад ажилтанд 2009 онд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгож, гүйцэтгэлээр 58 ажилтныг авч ажиллуулахдаа 8 хүний 3,5 сая төгрөгийн ажлын байрны төлбөр төлсөн, 4 хүний хасалтыг ХХҮГ болон ГИХАЭГ-аас хийлгээгүйгээс ажлын байрны төлбөрийг бүрэн төлөөгүй байна.*

1.22 Засгийн газрын 2001 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан "Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам"-ын 3.8-д заасны дагуу ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдсөн зарим аж ахуйн нэгжийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна.

1.23 Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх талаархи Засгийн газрын шийдвэр хугацаа алдаж гарснаас улирлын чанартай зам, барилгын ажил хугацаандаа хийгдэж амжихгүй болоход нөлөөлж байна. Засгийн газрын тогтоол гарсан хугацааг хүснэгтээр үзүүлбэл,

Он	Засгийн газрын тогтоолын дугаар, огноо					
	дугаар	16	58	59	151	211
2007	огноо	2007.2.9	2007.3.14	2007.5.04	2007.6.20	2007.8.30
	дугаар	76	125	135	158	283
2008	огноо	2008.2.27	2008.4.2	2008.4.9	2008.4.30	2008.7.9
	дугаар	102	123	158	228	264
2009	огноо	2009.4.8	2009.4.22	2009.5.27	2009.7.22	2009.8.27
	дугаар	96	104			
2010	огноо	2010.4.21	2010.4.28			

<sup>4</sup> АХГГАХМАТХ-ийн "хуульд өөрөөр заагаагүй бол ажлын байрны төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтын санд төвлөрүүлж, ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээнд зарцуулна"

<sup>5</sup> Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 23.1. Монгол Улсад албан, эсхүл хувийн хэргээр зорчигч, түр оршин суугч, албан, эсхүл хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач гадаадын иргэний оршин суух хугацаа сунгуулах тухай хүсэлтийг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянан шийдвэрлэнэ.

<sup>6</sup> Захиргааны хариуцлагын тухай хуулийн 28.6-д Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсад тодорхой хугацаагаар урьсан, ажиллуулах зөвшөөрөл авсан иргэн, байгууллага, аж ахуйн нэгж нь түүнийг хууль тогтоомжийн дагуу зохих байгууллагад бүртгүүлээгүй буюу эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн хугацаагхэтрүүлэн байлгасан иргэнийг 300 000-500 000, байгууллага, аж ахуйн нэгжийг 600 000-1000,000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.



1.24 Иймд нэгэнт гадаадаас ажиллах хүч авах зайлшгүй шаардлагатай бол уг асуудлыг Засгийн газраар тухайн оны эхний хоёр сард багтаан шийдвэрлүүлж байх нь зүйтэй юм.

1.25 Сүүлийн гурван жилд Засгийн газрын тогтоолоор 106 аж ахуйн нэгжийн 31 077 гадаадын иргэдийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхөөр шийдвэрлэсэн бөгөөд гүйцэтгэлээр 25 495 иргэний 27 133.3 сая төгрөгийн төлбөрийг чөлөөлсөн байна.

1.26 Эдгээрийн дотроос 2-3 жил дараалан ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдсөн аж ахуйн нэгжийг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

№	Аж ахуйн нэгжийн нэр	Улсын нэр	Засгийн газрын тогтоолоор АБТ-өөс чөлөөлсөн							
			2007		2008		2009		Нийт дүн	
			хүн	төлбөр	хүн	төлбөр	хүн	төлбөр	хүн	төлбөр
1	"Синохайдро" корпораци	БНХАУ	450				15	2,5	465	459,7
2	"Камко интернейшнл"	БНХАУ	182	457,2			60		242	
3	"Шанхай" групп	БНХАУ	275	247,5			65	18,1	340	265,6
4	"Насны зам"ХХК	Монгол БНХАУ	183	131,8	360	354,2	340	263,8	883	749,8
5	"Комбайнд" групп	БНХАУ	45	28,8	24	14,0	6	1,5	75	44,3
6	"Чайно Гео-Инженерг" корпораци	БНХАУ	342	219,6	600	571,1	780	115,6	1722	906,3
7	"Шингли Инженерг энд констракшн"	БНХАУ			180	170,6	292	282,7	472	453,3
8	"Ханшин Инженерг констракшн"	БНСУ	278	14,1	612	583,2	400	52,3	1290	649,6
9	"Петрочайна Дачин Тамсаг" ХХК	БНХАУ	3620	3172,5	3600	3888,0	3900	5538,3	11120	12598,8
10	"Доншен" ХХК	БНХАУ	480	432,0	570	333,7	350	198,4	1400	964,1
11	"Болдтөмөр Ерөө гол"ХХК	Монгол БНХАУ			150	162,0	200	133,9	350	295,9
12	"Чинхуа-Мак-Нарийн сухайт" ххк	Монгол БНХАУ	85	76,5	85	6,5	0		170	83,0
13	"Гандирс" ХХК	Монгол	180	129,6	450	321,2	150	105,1	780	555,9
14	"Их үйлсийн эрэлд" ХХК	Монгол БНХАУ	350	252,0	800	833,8	900	1346,0	2050	2431,8
15	"Голден сий петролум" ХХК	БНХАУ	378	272,2			150	64,8	528	337,0
16	"Сүрэг агт" ХХК	БНХАУ			120	216,0	200	276,6	320	492,6
17	"Богда холдинг"ХХК	БНХАУ	180	129,6	300	324,0	200	267,8	680	721,4
18	"Читай" ХХК	БНХАУ	120		191	145,8			311	145,8
20	"Шингли Инженерг энд констракшн"	БНХАУ			180	170,6	292	282,7	472	453,3
<b>Нийт дүн</b>			<b>7148</b>	<b>5563,4</b>	<b>8222</b>	<b>8094,7</b>	<b>8300</b>	<b>8950,1</b>	<b>23670</b>	<b>22608,2</b>

1.27 Үүнээс үзэхэд 9 аж ахуйн нэгж хоёр жил дараалан, 11 аж ахуйн нэгж, байгууллага гурван жил дараалан төлбөрөөс чөлөөлөгдсөн байна.

1.28 АХГГГАХМАТХууль болон холбогдох журмыг зөрчсөн аж ахуйн нэгжийг цаашид ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхгүй байх нь зүйтэй байна.

## Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний ажлын байрны төлбөрийг дутуу тооцсон тохиолдол байна

1.29 Зарим аж ахуйн нэгж, байгууллага АХГГАХМАТХууль болон “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ыг зөрчиж ажлын байрны төлбөрийг дутуу төлсөн байна.Тухайлбал,

- 2009 онд бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Дорноговь аймгийн Өргөн суманд газрын тосны хайгуул, судалгааны ажил гүйцэтгэж буй “Голден Си петролеум” ХХК-д БНХАУ-аас 310 ажилтанг Монгол Улсад оруулж хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл олгож, 150 хүнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн бөгөөд чөлөөлөгдөөгүй 5 хүний 1.1 сая төгрөгийн төлбөрийг дутуу төлсөн;
- Барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл болон гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг харгалзалгүйгээр БНХАУ-аас 400 ажилтан Монгол Улсад оруулж, хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл “Богда холдинг” ХХК-д олгосон боловч ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдөөгүй 2 хүний 2.9 сая төгрөгийн төлбөрийг дутуу төлсөн;
- “Задран” ХХК-д БНХАУ-аас 500 ажилтанг Монгол Улсад оруулж, хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл олгож, 250 хүнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхдөө барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл болон гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг харгалзахгүйгээр 10.0 сая төгрөгийн төлбөрөөс чөлөөлсөн.

1.30 Энэ нь АХГГГАХМАТХуулийн 9.1<sup>7</sup> болон Засгийн газрын 2001 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 3.11 дэх заалтыг зөрчсөн байна.

## Гадаадын ажиллах хүчний бүртгэлд тавих хяналт хангалтгүй байна

1.31 АХГГГАХМАТХуулийн 8.7-д “Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл бүхий гадаадын иргэн тухайн байгууллагатай байгуулсан хөдөлмөрийн гэрээний үүргээ биелүүлээгүй, гэрээ зөрчсөн, орон нутагт зөвшөөрөлгүй шилжин ажилласан тохиолдолд уг зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас хүчингүй болгож, гадаадын иргэн, харъяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ тухай мэдэгдэнэ” гэж заасан.

1.32 Гэтэл зарим аж ахуйн нэгж, байгууллага гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахдаа дээрх хуулийн 8.2-т заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлээгүй, хуульд заасан хугацаанд сунгалт болон хасалтыг хийгээгүй, эрх бүхий байгууллагад албан ёсоор мэдэгдэхгүйгээр зөвшөөрөл авсан компаниас өөр аж ахуйн нэгж, иргэнд шилжүүлэн ажиллуулсан зөрчил гарсан байна.Тухайлбал,

- “Очир төв”ХХК Улаанбаатар-Лүнгийн чиглэлийн автозамын ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор БНХАУ-ын 494 ажилтанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авч тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан “Дун Чан” ХХК-нд албан бусаар шилжүүлэн ажиллуулсан ба нэг хүний 2 сарын төлбөр 432.0 мянга, 19 хүний үнэмлэхний үнэ 38.0 мянган төгрөг, нийт 470.0 мянган төгрөг төлөөгүй, гүйцэтгэсэн ажлын зураг төсөл техникийн шаардлага хангаагүй, өмнө хийсэн зам нь эвдэрсэн, төлөвлөсөн ажил нь хугацаандаа дуусаагүй;

<sup>7</sup> АХГГГАХМАТХ-ийн 9.1-т “Аж ахуйн нэгж байгууллага, иргэн нь гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсний төлөө ажлын байрны төлбөрийг энэ хуулийн 9.2-т заасан хэмжээгээр төлнө”

- “Бумбод” ХХК барилга угсралтын ажил явуулах тусгай зөвшөөрөлгүй, бусад бичиг баримтын бүрдэл дутуу, НДЕГ-ын тодорхойлолтгүй байхад 112 иргэнд зөвшөөрөл авсан боловч, тэднийг өөрийн компанидаа ажиллуулалгүй бусдад шилжүүлсэн, хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан байхад ХХҮГ болон ГИХАЭГ-аар 4 хүний хасалтыг албан ёсоор хийлгээгүй;
- “Дөл түшиг” ХХК 124 гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан боловч нэг хүний ажлын байрны төлбөрийг дутуу төлсөн, зөвшөөрлийн хугацаа дууссан 15 хүний хасалтыг ХХҮГ-т хийлгээгүй орхигдуулжээ.

1.33 Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаад иргэдийн бүртгэл, мэдээллийг зарим аймгийн ХХҮХ тухайн аймгийнхаа ГИХАЭА-тай тулгалт хийж баталгаажуулаагүйгээс хөдөлмөр эрхэлж буй иргэдийн тоо зөрүүтэй гарсан байна. Тухайлбал,

- Увс аймгийн Улаангом суманд үйл ажиллагаа явуулж буй “Шинжиан Шинфа” ХХК 2009 онд ХХҮГ-аас 35 хүний хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан атал тухайн орон нутгийн Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албанаас авсан мэдээгээр 53 хүн 3-4 сарын хугацаанд хөдөлмөр эрхэлсэн буюу 18 хүний зөвшөөрлийг аваагүй, тэр хэмжээгээр ажлын байрны төлбөр төлөхөөс зайлсхийсэн байна.

1.34 Өөрөөр хэлбэл, АХГГГАХМАТХуулийн 9.1 “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсний төлөө ажлын байрны төлбөрийг энэ хуулийн 9.2-т заасан хэмжээгээр төлнө” гэсэн заалт бүрэн хэрэгжихгүй байна.

1.35 Ийнхүү гадаадаас ажиллах хүч авч байгаа зарим аж ахуйн нэгж зөвшөөрөл авсан иргэдийн хасалтыг зохих хуулийн хугацаанд хийлгэхгүй, харин ГИХАЭГ-аар торгуулийн арга хэмжээ тооцуулан ажлын байрны төлбөр төлөхөөс зайлсхийх хандлага ажиглагдаж байна.

1.36 2009 онд 780 аж ахуйн нэгжийн 17 680 хүнд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулах зөвшөөрөл олгосноос 613 иргэн нь ХХҮГ-аас хасалт хийлгэлгүй ГИХАЭГ-т торгууль төлж гарчээ. Торгуулийн хэмжээ ажлын байрны төлбөрөөс бага байдаг нь үүнд нөлөөлж байна.

1.37 Иймд гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллийн санг бүрдүүлж, холбогдох байгууллагын ажлын уялдааг сайжруулах шаардлагатай байна.

## **2009 оны сангийн хөрөнгийн төсөвт хоёр удаа тодотгол хийжээ**

1.38 ХЭДТХ-д зааснаар төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого нь хүн амын хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээтэй уялдуулах, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг оновчтой зохицуулах, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх, хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бүртгэл мэдээллийг боловсронгуй болгох, ажилгүйдлийн даатгалд хамрагчийн хүрээг өргөтгөж, иргэн бүрийг ажилгүйдлээс хамгаалахад чиглэгдэхээр заажээ.

1.39 ХХҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаа нь халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, аппаратын төсөв гэсэн үндсэн хэсгээс бүрдэж байна.

1.40 НХХС дээрх сангууд болон үйл ажиллагааг зардлын зүйлээр, ХХҮГ-ын дарга нийслэл, аймаг, дүүрэг, бусад харьяа байгууллагын төсвийг хуваарилдаг.

1.41 ХЭДС-д 2009 онд 23 595.8 сая төгрөг зарцуулахаар төсвийн тухай хуулиар батлагдсан бөгөөд төсөвт хоёр удаа тодотгол хийхдээ нийт дүнд нэмэлт, хасалт хийлгүй, зардлын зүйл хооронд өөрчлөлт хийжээ. *Үүнийг хүснэгтээр үзүүлбэл,*  
(сая төгрөгөөр)

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зардлын ангилал	2009 оны төсөв		Тодотгол (2009 оны 7 дугаар сар)		Тодотгол (2009 оны 11 дүгээр сар)	
	хүн	хөрөнгө	хүн	хөрөнгө	хүн	хөрөнгө
Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэх иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	36200	13486,0	36350	9683,0	29700	11373,0
Нийтийг хамарсан ажил зохион байгуулах	10500	1260,0	25000	3000,0	26940	3220,0
Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд	2460	1979,7	5260	3733,7	4962	3148,0
Мэргэжил олгох, давтан сургалт	10000	1937,0	11500	2237,0	12146	2351,8
ХЭД шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх үйл ажиллагааны зардал		2750,0		3020,0		1970,0
ХЭ-ийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх, ажилтнуудын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх сургалт, семинар зохион байгуулах, хяналт хийхэд		880,4		639,4		510,0
Иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд	50000	432,0	50000	432,0	50000	358,0
Ажилд зуучлахад	50000	350,7	50000	350,7	50000	335,0
Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ		320,0		300,0		180,0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ зохион байгуулах	520	200,0	520	200,0	520	150,0
<b>Зарлагын дүн</b>	<b>159680</b>	<b>23595,8</b>	<b>178630</b>	<b>23595,8</b>	<b>174268</b>	<b>23595,8</b>

1.42 Хүснэгтээс харахад төсвийн тодотгол хийснээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах хүний тоо 14 588 хүнээр өссөн ба тухайн цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зарим зардлын зүйлийг хооронд нь гүйлгэсэн байна. Тухайлбал,

- *Нийтийг хамарсан ажил зохион байгуулах зардал анх батлагдсанаас 2.6 дахин өсч 3 220.0 сая, хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зардал 2 113.0 сая төгрөгөөр буурч 11 373.0 сая төгрөг болсон байна.*

1.43 ХЭДС-гийн хөрөнгийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах, мэргэжлийн сургалтад хамруулах, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, ажил олгогчийг дэмжих, хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийг мэдээллээр хангах, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан хуваарилжээ.

1.44 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд 21 аймаг, 9 дүүргийн ХХҮХ, хөдөлмөрийн төв бирж, нийслэлийн хөдөлмөрийн газар болон гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэд<sup>8</sup> хамрагддаг байна.

1.45 ХЭДС-гийн хөрөнгийг хуваарилахдаа Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээ, томоохон хэмжээний төсөл, хөтөлбөрт хамрагдах хүн, зарцуулах хөрөнгө, мөн аймаг, дүүргийн болон суурин хүн ам, бүртгэлтэй ажилгүйчүүд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоог харгалзан үздэг байна.

---

<sup>8</sup> ХЭДТХ-ийн 6.1-д хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хөдөлмөрийн зах зээлийн харилцаанд оролцогч ажилгүй иргэн, ажил хайгч болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олгогч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл санаачлагч, хэрэгжүүлэгч хамрагдана.

## БҮЛЭГ 2

### Сангийн зарцуулалт болон зээлийн ашиглалт хангалтгүй байна

#### Оршил

2.1 2009 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйлчилгээ, арга хэмжээнд давхардсан тоогоор 284.6 мянга гаруй иргэн хамрагдаж нийт 21 494.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

(сая төгрөгөөр)

№	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйлчилгээ, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэнийг дэмжих зээл	9 900.0	9 050.0
2	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах	3 220.0	3 156.4
3	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	3 148.0	2 820.6
4	Мэргэжил олгох, давтан сургалт	2 351.8	2 188.7
5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх	1 970.0	1 596.8
6	Бизнес инкубацийн үйлчилгээ, аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалт	1 473.0	1 321.8
7	Хөдөлмөр эрхлэлтийн албаны материаллаг баазыг бэхжүүлэхэд	393.9	381.5
8	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах	358.0	297.9
9	Ажилд зуучлах	335.0	291.1
10	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох	180.0	151.1
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	150.0	129.3
12	Ажилтнуудын мэдлэг мэргэшлийг дээшлүүлэхэд	82.1	85.8
13	Хяналт, шалгалтын зардал	25.0	14.7
14	ХЭҮЗ-ийн зардал	9.0	8.7
<b>Дүн</b>		<b>23 595.8</b>	<b>21 494.3</b>

2.2 Нийт зардлын 42.1 хувийг хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэнийг дэмжих зээл олгоход, 14.7 хувийг нийтийг хамарсан ажил зохион байгуулахад, 13.1 хувийг ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд, 10.2 хувийг мэргэжил олгох, давтан сургалтад, 7.4 хувийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэхэд, 6.1 хувийг бизнес инкубацийн үйлчилгээ, аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтад, 6.4 хувийг бусад зардалд зарцуулжээ.

#### Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих явцын хяналт хангалтгүй байна

2.3 Засгийн газрын 2002 оны 31 дүгээр тогтоолоор ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах зорилгоор “Нийтийг хамарсан ажил зохион байгуулах” журмыг баталжээ.

2.4 Улсын хэмжээгээр нийтийг хамарсан ажилд 51 126 хүн оролцсоноос 79.6 хувь нь аймаг, дүүргийн ХХҮХ-т бүртгэлтэй ажилгүй иргэд, 20.4 хувь нь хөдөлмөр

эрхэлдэггүй иргэд байна. Үүний 49.6 хувь нь эмзэг бүлгийн, 0.6 хувь нь 8, 10 дугаар анги төгсөгчид, 0.1 хувь нь цэргээс халагдсан болон хорихоос суллагдсан иргэд байна.

2.5 2009 онд нийтийг хамарсан ажлын хүрээнд 505.6 км замыг шинээр тавих ба сэргээн засварлаж, 60 худаг засаж, 269.0 мянган мод, бут, сөөг суулгаж, 35.4 км урт далан сувгийг засварлаж, 317.4 м<sup>2</sup> талбайг зүлэгжүүлж, 1031.5 мянган тн хог хаягдал цэвэрлэн зайлуулж, ойн цэвэрлэгээ хийснээр 2.5 мянган тн түлш бэлтгэж, 935.4 га газар ойжуулалт, 569.4 га газарт тариалалт хийж, 23.2 мянган тн ургац хураан, 946 тн хадлан бэлтгэж, 30 км усжуулалтын суваг шуудуу сэргээн засварлажээ.

2.6 Гэвч нийтийг хамарсан ажлын гүйцэтгэл болон хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт сул байгаагаас дараахь зөрчил илэрсэн байна. Тухайлбал,

- Говьсүмбэр аймгийн ХХҮХ НХХС-ын 2006 оны 80 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.1.4<sup>1</sup> дэх заалтыг зөрчин 3246.0 мянган төгрөгөөр бараа материал бэлтгэсэн, гадна талбайн тохижилтын ажилд 1.5 сая төгрөгийг давхардуулан олгосон, 1.8 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл хүлээлгэн өгсөн баримт байхгүй;
- Хэнтий аймгийн ХХҮХ-т нийтийг хамарсан ажлыг гүйцэтгэсэн гэх боловч баримт материал нь олдоогүй, зориулалт бусаар зарцуулсан, төслийн баримт материал хуурамчаар бүрдүүлэн 9.1 сая, орон нутгийн бус иргэнд төсөл хэрэгжүүлэхээр мөнгө олгосон ч ажил нь хийгдээгүй, төсөл хэрэгжүүлэгчээ олохгүй болсноос 4.9 сая, нийт 14.0 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэн;
- Баян-Өлгий аймагт байгууллагын үйл ажиллагааны зардлаас гүйцэтгэх ажлуудыг нийтийг хамарсан ажлын зардлаар санхүүжүүлсэн буюу аймгийн нийгмийн даатгал, татварын хэлтэс, ХХҮХ болон хувийн компанийн конторын засварт 10.9 сая төгрөг зарцуулсан;
- Баянхонгор аймаг 9 төслөөр ногоон байгууламж, гэрэлтүүлгийн ажилд 17.4 сая төгрөг зарцуулсан боловч бүрэн хийгдээгүй;
- Өвөрхангай аймагт нийтийг хамрах 7 ажил үйлчилгээнд хяналт сул тавьснаас 3.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг биелснээр тооцож 7.4 сая төгрөг авсан;
- Завхан аймгийн ХХҮХ –ээс нийтийг хамарсан ажилд олгосон 3.9 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл бүрэн гараагүй.

2.7 ХЭДТХуулийн 11.1<sup>2</sup> дүгээр зүйлд зааснаар 16 хүртэлх дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг, хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 45-аас дээш насны ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ЕБС, МСҮТ төгссөн хөгжлийн бэрхшээлтэй болон бүтэн өнчин хүүхэд, ХЭА–нд бүртгүүлснээс хойш нэг жилээс дээш хугацаагаар ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа ажил олгогчид ажил олгогчийг дэмжих арга хэмжээний зардал зарцуулагдах ёстой.

<sup>1</sup> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын төрөл, хамрагдах иргэнд тавигдах нөхцөл, шалгуурыг тодорхойлох журмын 2.1.4-т Нийтийг хамарсан ажлын төсөвт өртөгт тусгагдсан хөдөлмөрийн хөлсний нийт хэмжээ, купон хэвлүүлэх зардал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаад, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон мэдээлэл, зөвлөлгөө өгөх зардлууд багтана.

<sup>2</sup> ХЭДТХ-ийн 11.1-д Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй дор дурдсан иргэнийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа ажил олгогчид тус албатай байгуулсан гэрээний дагуу нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тухайн ажилтанд эхний 6 сарын хугацаанд олгосон цалин хөлсний 60 хувийг ХЭДС-гаас нөхөн олгоно.

2.8 Гэтэл зарим аймагт ажил олгогчийн урамшууллыг төсвийн байгууллагад бэлнээр олгосон, оюутнуудыг ажилгүй иргэн гэж бүртгэн урамшуулал олгосон тохиолдол аудитаар илэрсэн байна.Тухайлбал,

- Говьсүмбэр аймагт 4 оюутныг ажилд авч 2948.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон, НД-ын хэлтсийн тодорхойлолтгүйгээр ажил олгогчоос ирүүлсэн цалингийн тодорхойлолтыг үндэслэн 855.5 мянган төгрөг илүү олгосон;
- Баянхонгор аймагт ажил олгогчийг дэмжихэд олгосон хөрөнгийг тулган баталгаажуулахад нэр бүхий 2 компанид сайн дурын даатгуулагчийн нэрээр 2.2 сая төгрөг олгосон;
- Мөн тус аймагт нийтийг хамарсан ажилд оролцсон иргэдийн нэрээр 2.1 сая төгрөгийг ажил олгогчийн урамшуулалд авсан;
- Увс аймгийн ХХҮХ нь ХЭДТХ-ийн 11.1-д заасан заалтыг зөрчиж урамшуулал тооцсон, хөдөлмөрийн чадваргүй, тахир дутуугийн групптэй хүнд, өндөр насны тэтгэвэрт гарсан, ерөөсөө ажиллаагүй хүмүүсийг ажилласнаар тооцон 13.3 сая төгрөг олгосон;
- Архангай аймагт ажлын байртай болгосон нь баримтаар нотлогдоогүй 3 ажил олгогчид 4.8 сая төгрөг олгосон.

2.9 НХХС, ЗТБХБС, ЭБЭХС нарын 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 44/74/49 дугаар хамтарсан тушаалаар “Уул уурхай, зам, барилгын салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх үйлдвэрлэл дээрх сургалтын дэд хөтөлбөр”-ийг баталж, уг хөтөлбөрт зарцуулах хөрөнгийг энэ зардалд тусгасан байна.

2.10 Дээрх тушаалаар баталсан 12 хүний бүрэлдэхүүнтэй зохицуулах зөвлөл “үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулах хөтөлбөр”-т хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулжээ.

2.11 Уг шалгаруулалтад 96 аж ахуйн нэгж, байгууллага зам, барилгын салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх хүсэлт гаргаснаас 82 нэгжийг сонгосон байна.

2.12 ХХҮГ болон ЗТБХБЯ-ны харьяа ССХОБЗА, тендерт сонгогдсон аж ахуйн нэгж, байгууллагууд гурвалсан гэрээ байгуулж, сургалтын зардлыг тооцохдоо НХХС-ын 2007 оны 96<sup>3</sup> дугаар тушаалыг үндэслэжээ.

2.13 Дээрх гэрээний 1.6-д заасны дагуу үйлдвэрлэл дээрх сургалтын үйл ажиллагаанд байнгын хяналтыг ХХҮГ, мэргэжлийн арга зүйгээр хангах, мэргэжлийн чиглэл бүрээр ур чадварын шалгалт авах, хөндлөнгийн хяналт тавихад ЗТБХБЯ-ны харьяа ССХОБЗА-ны мэргэжилтнүүд ажиллахаар тусгажээ.

2.14 2009 онд үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулсан салбараар харуулбал;

(сая төгрөгөөр)

№	Салбар	Аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Сургалтад хамрагдсан иргэний тоо	Санхүүжилт
1	Уул уурхай	11	569	308.3
2	Зам	14	560	263.6
3	Барилга	68	2407	1093.6
<b>Нийт дүн</b>		<b>93</b>	<b>3536</b>	<b>1665.5</b>

<sup>3</sup> НХХС-ын 96 дугаар тушаалын дагуу нэг суралцагчид 3 сараас дээшгүй хугацаагаар сард 280000-550000 төгрөг олгоно



2.15 Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагын 73.2 хувь нь барилга, 15 хувь нь зам, 11.8 нь хувь уул, уурхайн салбарынх байна.

2.16 Үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулсан зарим аж ахуйн нэгжийн сургалт явуулсан үйл ажиллагаатай танилцахад сургалтад хамрагдагсдын хичээлийн хөтөлбөр болон сургалтын анхан шатны баримт материал дутуу, сургалтын гэрээгээ дүгнээгүй, тайлангаа өгөөгүй зэрэг зөрчил дутагдал илэрлээ. Тухайлбал,

- “Заамарын Их Алт” ХХК, “Хөнгөн бетон” ХХК, “Азаргын гол чонот” ХХК, “Дархан шар бүрд” ХХК-ууд үйлдвэрлэл дээрх сургалтын гэрээг хугацаанд нь дүгнээгүй, тайлан, мэдээ ирүүлээгүй, сургалт явуулсан эсэх нь тодорхойгүй;
- Мөн “Заамарын Их Алт” ХХК үйлдвэрлэл дээрх сургалт явуулж, хүмүүсийг сургаасан боловч зохих мэргэжлээр нь ажиллуулаагүй;
- Баянхонгор аймгийн ХХҮХ-ээс үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулсан “Нимонс” ХХК-д 6.5 сая төгрөг шилжүүлсэн боловч сургалтад хамрагдсан хүмүүсийн судалгаа, олгосон мэргэжлийн үнэмлэх байхгүй байлаа.

2.17 Энэ байдал нь ХХҮГ-ын сургалт хариуцсан ажилтнуудын үйлдвэрлэл дээрх сургалтын явцад тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

2.18 НХХС-ын 2005 оны 25 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох” журмын дагуу ХЭДС-гаас мэргэжил олгох эрхийн бичгийн сургалтад 2188.6 сая төгрөг зарцуулжээ.



2.19 ХХҮГ-ын даргын 2008 оны 115 дугаар тушаалаар эрхийн бичгийн сургалтын сонгон шалгаруулалтын үнэлгээний хороог баталсан байна.

2.20 2009 онд мэргэжил олгох, ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах тендерт 130 сургалтын төв материал ирүүлснээс 120 сургалтын төвийг шалгаруулжээ.



2.21 Тендерийн бичиг баримтын 61.6 хувийг шалгахад тендерийн үндсэн шалгуурыг хангасан баримт, материалтай сургалтын төв цөөн байлаа.

2.22 Сургалтын төвийг сонгон шалгаруулахдаа: “орон нутаг болон дүүрэг тус бүрээс сургалтын төв заавал сонгон шалгаруулах”-ыг гол нөхцөл болгож байгаа нь зүйтэй боловч, тендерийн бичиг баримтын иж бүрдэл, материал, үнэн зөв эсэхийг харгалзаагүй, ТБОНӨХБАҮХАТХуулийг баримтлаагүй, сургалтын төвийн материаллаг бааз, багш нарын ур чадварыг үнэлээгүй байна.

2.23 ХХҮГ-аас сургалтын төвүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт семинар явуулах, санхүүжүүлэх эрхийг “Жижиг дунд үйлдвэрийн хөгжил” болон “Барилгын инженерүүдийн холбоо” ТББ-д олгожээ.

2.24 Дээрх байгууллагууд сургалтын төвүүдтэй гэрээ байгуулж, сургалтад оролцох эрхийн бичгийг иргэдэд түгээх, сургалтын хөтөлбөрийн дагуу явцын хяналт тавьж, санхүүжилтийг гүйцэтгэлээр тооцон шилжүүлсэн байна. Ингэж ТББ-аар дамжуулан сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ирсэн нь үр дүнтэй байна.

2.25 Харин хөдөлмөр халамжийн үйлчилгээний орон нутаг дахь хэлтсээс эрхийн бичгийн болон мэргэжлийн түр сургалтын явцад тавих хяналт сулаас дараахь зөрчил илэрлээ.

- *Говьсүмбэр аймагт 1.8 сая төгрөгийг сургалтын зардалд илүү тооцсон, 6.7 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан;*
- *Хэнтий аймагт сургалтад хамрагдсан иргэдийг тодруулахад 2009 оноос өмнө нас барсан хоёр иргэн, регистрийн дугааргүй 47 иргэн, сургалтад суугаагүй 104 иргэдийг бүртгэлд оруулах замаар сургалтын материалыг хуурамчаар бүрдүүлсэн, зарим сургалтыг зохион байгуулах эрхгүй байгууллагаар гүйцэтгүүлсэн, чадамжийн гэрчилгээг 41 хүнд олгоогүй;*
- *Ховд аймагт сургалтынхаа үндсэн чиглэлээс өөр мэргэжлээр сургалт явуулсан;*
- *Сэлэнгэ аймагт сургалтын зардлыг 1.3 сая төгрөгөөр илүү тооцож олгосон;*
- *Баянхонгор аймагт сургалт явуулах эрх нь дууссан нэр бүхий 5 байгууллагатай гэрээ байгуулсан, сургалтын чиглэлийг өөрчилсөн, сургалт явуулах эрхийн гэрчилгээгүй, гэрээгүй “Анд бизнес” сургалтын төвд 6.6 сая төгрөг олгосон;*
- *Увс аймагт 200 хүнд зөвлөгөө өгсөн, сургалтад материал зарцуулснаар хуурамч баримт бүрдүүлэн 2.0 сая төгрөгөөр 3 компьютер худалдан авсан;*
- *Төв аймгийн ХХҮХ төлбөрийн лимит тогтоосон хэмжээнээс илүү үнээр “Футур” сургалтын төвтэй гэрээ байгуулж 1.1 сая төгрөг илүү олгосон;*
- *Өвөрхангай аймгийн Хархорин сумын ХЭСТ сургалт зохион байгуулаагүй боловч 2.8 сая төгрөгийг хийснээр тайлагнасан, сургалтын зардлаас 4.8 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан ;*
- *Баян-Өлгий аймагт мэргэжлийн түр сургалт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт явуулсан талаарх нотлох баримт хангалттай бус, сургалт явуулсан явцыг баримтжуулаагүй байна.*

2.26 ХХҮГ-аас түгээмэл 15 мэргэжлээр “чадамжид суурилсан модуль хөтөлбөр”, интерактив програмаар видео хичээлийг DVD, CD дээр 1500 ширхгийг 31.0 сая төгрөгөөр ГҮБ ХХК-тай гэрээ байгуулан хэвлүүлсэн боловч аймаг, дүүргийн ХХҮХ болон холбогдох газруудад бүрэн тараагаагүй байна.

2.27 Уг ажлыг гүйцэтгэхдээ ТБОНӨХБАҮХАТХуулийн 7.1<sup>4</sup> дэх заалтыг зөрчсөн байна.

2.28 ХЭДТХуулийн 15.1.8<sup>5</sup>-д заасны дагуу ХЭДС-гаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх арга хэмжээнд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын дэд хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”, Хөдөлмөрийн төв биржийн үйл ажиллагааны зардал тусгагдсан байна. Хүснэгтээр харуулбал,

<sup>4</sup> ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1.Захиалагч бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа дор дурьдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлана.

<sup>5</sup> ХЭДТХ-ийн 15.1.8-д ХЭД шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх

№	Хөтөлбөрийн нэр	Төслийн тоо	Хамрагдсан хүн	(сая төгрөгөөр)
				Зарцуулсан хөрөнгө
1	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	10 аймаг	800 малчин	585.6
2	Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын дэд хөтөлбөр	5 сургууль	19304 оюутан	226.2
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	152	402	614.6
4	Хөдөлмөрийн төв бирж			145.5
	<b>Нийт дүн</b>			<b>1571.9</b>

2.29 “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т 10 аймгийн 36 сумын 210 малчин өрх хамрагдаж, үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах, малжуулах, зээл олгох, туршлага солилцох, үзэсгэлэн зохион байгуулах, бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах болон нийтийг хамарсан ажил зохион байгуулахад зарцуулсан байна. Гэвч уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Сэлэнгэ аймагт хөтөлбөрийн хүрээнд 39.9 сая төгрөгийн мал худалдан авахдаа тендер зарлаагүй, үнийн харьцуулалт хийгээгүй;
- Архангай аймаг дээрх хөтөлбөрөөс 16.6 сая төгрөгийг малчны сургалтад зарцуулсан;
- Булган аймагт дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ яамнаас баталсан сумдыг хамруулаагүйн дээр мал худалдан авахад 29.2 сая, тэжээлд 2.3 сая, тарилга туулгалтад 3.2 сая төгрөг зарцуулж, үлдсэн хөрөнгийг зөвлөгөө мэдээлэл, гарын авлага, сурталчилгаа, нийтийг хамарсан ажил, туршлага солилцох, үзэсгэлэн худалдаа, зөвлөгөөн гэх мэт зүйлд зарцуулсан;
- Өвөрхангай аймагт хөтөлбөрт хамрагдсан малчдыг туршлага судлуулахад зориулан 4.5 сая төгрөг зарцуулсан байна.

2.30 Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлсэн аймгуудын тайлангаас үзэхэд хэрэгжүүлсэн ажлын талаарх тайлан, мэдээг тогтмол гаргах асуудал орхигдсон, зарцуулалтын баримтын бүрдүүлэлт хангалтгүй, үр ашиг багатай зүйлд зарцуулж үрэлгэн хандсан байдал ажиглагдаж байна.

2.31 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийг НХХЯ-ны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан салбар зөвлөлөөс шалгаруулж, нийт 127 төсөлд 424.9 сая төгрөг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд төсөлд тавигдах шаардлагыг зөрчин 41 төсөлд 67.1 сая төгрөг илүү олгожээ.

2.32 2009 онд хөдөлмөрийн төв биржийн бүтэц, зохион байгуулалтыг баталж, 145.5 сая төгрөг зарцуулсан байна.

2.33 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх хүрээнд хэрэгжүүлж байгаа дээрх төсөл, хөтөлбөрийн үр дүн, үр өгөөжийг тооцож, зарцуулалтад хяналт тавих асуудлыг сайжруулах шаардлагатай байна.

2.34 Засгийн газрын 2006 оны 166 дугаар тогтоолоор ХЭДС-гаас “Бизнес инкубацийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх журам”-ыг баталж, ХХҮГ-ын даргын 2008

оны 114 дүгээр тушаалаар БИТ, БХДТ-ийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

2.35 Тус хороо 2009 оны нэгдүгээр сард бизнес инкубаторын 12, бизнесийн хөгжлийг дэмжих 26, аж ахуй эрхлэлтийн сургалтын 9 төвийг сонгон шалгаруулжээ.

2.36 ХХҮГ-аас дээрх арга хэмжээний хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ирсэн байна. Гэвч Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ- БИТ” 4 хүнд зээлийн хүүгийн нөхөн төлбөр олгосон гэж худлаа тайлагнан 2.8 сая төгрөг хувьдаа ашигласан зөрчил илэрлээ.

2.37 ХЭДТХ-ийн 8.1-т “Хөдөлмөр эрхлэхийг хүссэн ажилгүй иргэн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн алба бүртгэж, ажил олгогчийн эрэлт, хэрэгцээг үндэслэн ажилд зуучилна” гэж заажээ.

2.38 ХХҮГ-ын гаргасан мэдээ судалгаанаас харахад улсын хэмжээнд 2007-2009 онд 159 799 хүн зуучлагдан ажилд орсон боловч ажилгүйдлийн тоо бодитой буураагүй нь харагдаж байна.

- *Дархан-Уул аймагт ажилд зуучлагдсан 374 хүнийг тулган баталгаажуулахад ажилд орсныг нотлох баримт алга байна.*

2.39 2008 онд ХХҮГ-т ҮАГ-аас хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс байгуулагдан ажиллаж байна.

2.40 Тус хэлтэс өнгөрсөн хугацаанд 9 аймаг, 5 дүүргийн ХХҮХ-т шалгалт хийж, 294.7 сая төгрөгийн зөрчил дутагдал илрүүлж, албан даалгавар, шаардлага хүргүүлсэн байна.

2.41 Аймаг, орон нутагт хийсэн аудитаар дараахь зөрчил дутагдал илэрчээ.

- *Ховд аймагт 2007-2009 оны судалгаанаас үзэхэд түр сургалтад хамрагдагсдын тоо өмнөх оноос 122-249 хүнээр, сургалтын дараах ажил эрхлэлт 348 хүнээр тус тус буурсан байхад зарцуулсан хөрөнгө 9.5 сая төгрөгөөр өссөн;*
- *Баян-Өлгий аймгийн ХХҮХ-ээс хүмүүсийг ажлын байртай болгосон гэсэн үндэслэлээр тухайн байгууллагын удирдлагуудыг 2.0 сая төгрөгөөр шагнасан.*
- *Баянхонгор аймгийн ХХҮХ-ээс хяналт тавих эрх бүхий хүмүүс ТББ-ын нэрээр нийтийг хамарсан ажил, сургалтын төсөл хийж мөнгө авсан;*
- *Дундговь аймгийн ХХҮХ-ийн дэргэдэх сургалтын төвийн санхүүгийн тайлан тэнцэл санхүүгийн нэгдсэн тайланд тусгагдалгүй орхигдсон;*
- *ХЭДС-гийн хөрөнгөөс үйл ажиллагааны урсгал зардалд Ховд аймаг 14.2 сая, Сүхбаатар аймаг 2.1 сая төгрөг зарцуулсан;*
- *Булган аймгийн ХХҮХ сангийн тайлан тэнцлийг зөрүүтэй гаргасан, анхан шатны баримт материалын бүрдэл хангалтгүй, зардлыг зүйл ангиар хэтрүүлж төлөвлөгдөөгүй зардалд хөрөнгө зарцуулсан;*
- *Мөн ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд гэж үндсэн баримтгүйгээр 54.5 сая төгрөгийг хувь хүний харилцах дансанд шилжүүлсэн.*

2.42 Цаашид ХЭДС-гийн хөрөнгийг оновчтой, далайцтай, үр бүтээлтэй бүтээн байгуулалтын ажилд чиглүүлж, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

### **НХХЯ зарим тендерийг сонгон шалгаруулаагүй байна**

2.43 Хувиараа болон өрхийн аж ахуй, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хүсэгч ажилгүй иргэн, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ХЭДС-гаас банк, ББСБ-аар дамжуулан 2007 онд 9 780.0 сая төгрөг, 2008 онд 16 150,0 сая, 2009 онд 9 050.0 сая төгрөг нийт 34 980.0 сая төгрөгийн зээлийг (*давхардсан тоогоор*) олгосон байна.



2.44 ТБОНӨХБАҮХАТХуулийн 45. 2.2<sup>6</sup> дахь заалтыг зөрчин НХХЯ 2007-2009 онд 26 000,0 сая төгрөгийн жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэх банкыг сонгох сонгон шалгаруулалтыг явуулаагүй учраас ХХҮГ сонгон шалгаруулалтыг гүйцэтгэсэн байна.

2.45 ХЭДС-гаас банк, банк бус санхүүгийн байгууллагад байршуулах зээлийн эх үүсвэрийг НХХС-ын баталсан төлөвлөгөөний дагуу 1 900.0 сая төгрөгөөр нэмж гэрээ байгуулжээ.**(Хавсралт № 2)**

### **Зээл нь ажилгүйдлийг бууруулахад дорвитой нөлөөлж чадахгүй байна**

2.46 ХЭДС-гаас олгож байгаа зээл нь аймаг, дүүргийн ХХҮХ-ийн сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан, ХЭА-д бүртгүүлсэн ажилгүй иргэн, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн ажлын байр шинээр бий болгох зорилгоор олгогдох ёстой.

2.47 Гэтэл ХХҮГ аймаг, дүүргийн ХХҮХ-ийн тодорхойлолттой, ажил хайж байгаа талаар бүртгүүлсэн, сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан, ажлын байр бий болгох гэрээ байгуулсан иргэдэд зээл олгож байгаа мэдээг банк, ББСБ-аас олгосон зээлдэгчийн мэдээтэй тулган хянадаггүйгээс шинээр бий болж байгаа ажлын байрны тоо, ажилгүй иргэн, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд зээл олгогдож байгаа эсэх нь тодорхой бус байна.

2.48 Зээлийн хэрэгжилтийг аудитын явцад түүвэрчлэн шалгахад доорхи зөрчил илэрлээ. Үүнд:

- ХХҮГ 2008 онд “Арвис Итгэл” ББСБ-тай хийсэн гэрээний хэрэгжилтийг түүвэрчлэн үзэхэд аймаг, нийслэлийн ХХҮХ-ийн тодорхойлолтгүй, ажлын байр нэмэгдүүлэх гэрээгүй иргэдэд нийт 20.0 сая төгрөгийн зээл олгосон.
- Сүхбаатар аймгийн Халзан сумын Хаан банк сумын ХХҮХ-ийн байцаагчийн тодорхойлолтгүй 4 иргэнд 11.5 сая төгрөгийн зээл олгосон.
- Дархан-Уул аймгийн Хонгор сумын Хаан банк ХХҮХ-ийн тодорхойлолтгүй 3

<sup>6</sup> ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45 дугаар зүйлийн 2.2-т Төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хэрэгцээнд худалдан авах 200.0 саяас дээш төгрөгийн өртөг бүхий бараа, үйлчилгээ, 500.0 саяас дээш төгрөгийн өртөг бүхий ажлын хувьд худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах гэж заасан.

иргэнд 5.5 сая төгрөг, МШБ 3.0 сая төгрөгийн зээлийг иргэдэд тус тус олгосон;

- Мөн Дархан-Уул аймагт ажлын байр нэмэгдүүлээгүй 5 зээлдэгчдэд 10.0 сая төгрөгийн зээлийг дахин олгосон; Мөн зээлийн үр дүнд ажлын байр, орлоготой болсон байх 292 иргэнийг тус аймгийн НДХ-ийн НДШ төлөлтийн мэдээтэй тулган шалгахад 10 хүрэхгүй хувь нь шимтгэл төлж түр ажлын байраар хангагдсанаас ХЭДС-аас олгосон зээлийн 82,9 хувь буюу 271.1 сая төгрөг нь ажлын байр нэмэгдүүлээгүй;
- Булган аймагт сангаас олгосон зээлийн үр дүнд ажилгүйдэл буурсан, байнгын болон түр ажлын байр бий болж, хөдөлмөр эрхлэлтийн тоо, зээл авсан иргэдийн орлого нэмэгдсэн гэсэн албан ёсны тоо, мэдээ, баримт байхгүй;
- Дархан-Уул аймгийн ХХҮХ зээлийн хүүгийн нөхөн төлбөрт 14 хүнд 925.8 мянган төгрөг олгосны 2 зээлдэгч нь ажлын байр нэмэгдүүлээгүй атлаа 130.3 мянган төгрөгийн зээлийн хүүгийн хөнгөлөлт авчээ.

2.49 Өөрөөр хэлбэл ХХҮГ болон хэлтсүүд зээлийн хэрэгжилтийн талаар банк, ББСБ-аас ирүүлсэн мэдээг үндэслэж, ажилгүйчүүдийн тоо багасч байгаа мэтээр тайлагнажээ.

2.50 Зээлийн үйл ажиллагааг явуулж байгаа банк, ББСБ-ын зээл олголтын мэдээ нь хэлтсүүдийн гаргаж байгаа мэдээтэй зөрж байгаад ХХҮГ хяналт тавихгүй байна. Тухайлбал:

- Арилжааны банкнуудаас 2007-2009 оны ХХҮГ-т ирүүлсэн зээл олголтын мэдээг аймгуудын ХХҮХ-ийн зээлийн мэдээ болон аймгуудын салбар банкуудын зээл олголттой тулган баталгаажуулахад нийт 13 аймгийн зээл олголт 503.3 сая төгрөгөөр зөрүүтэй буюу дутуу олгогдсон байна. **(Хавсралт №3)**
- Хөвсгөл аймагт 2007-2009 онд олгосон ХХҮХ-ийн зээлийн мэдээ нь банкны зээлийн мэдээнээс 67 зээлдэгчээр буюу 39.7 сая төгрөгөөр илүү зээл олгогдсоноор тайлагнагдсан нь зээлийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй, түүнд тавих хяналт сул байгааг харуулж байна.

2.51 ХХҮГ Засгийн газрын 2006 оны 166 дугаар тогтоолоор батлагдсан ХЭДС-гаас зээл олгох, зээлийн хүүг нөхөн төлөх журмын 4.4<sup>7</sup> дүгээр заалтыг хэрэгжүүлээгүйгээс сангийн эх үүсвэр банк, ББСБ-д их хэмжээгээр үлдэж байгаа нь өөр эх үүсвэрт ашиглах боломжийг бүрдүүлж байна. Тухайлбал:

- “Сан траст” ББСБ-ын 2007 оны, “АБТС” ББСБ-ын 2007-2008 оны зээлийн үйл ажиллагааг шалгахад ХЭДС-гаас жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэх гэрээний 5.2<sup>8</sup>-ыг зөрчиж өөрийн үйл ажиллагааны дансад дээрх зээлийн эх үүсвэрийг байршуулсан байна.

2.52 Банк, ББСБ зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийг бүрэн хариуцдагаас ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зорилттой уялдахгүй, өөрөөр хэлбэл барьцаа хөрөнгөгүй, ажилгүй, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд зээл олгогдохгүй байна.

<sup>7</sup> ХЭДС-гаас зээл олгох, зээлийн хүүг нөхөн төлөх журмын 4.4-т ХЭ-ийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь шинээр бий болгох, өргөтгөх ажлын байрны талаар зээлдэгчтэй байгуулсан гэрээг үндэслэн ажлын байрны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлнэ.

<sup>8</sup> ХЭДС-гаас жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэх гэрээний 5.2-т банк зээлийн эх үүсвэрийг тусгай дансанд байршуулна гэж заасан.

2.53 Засгийн газрын 2006 оны 166 дугаар тогтоолоор батлагдсан ХЭДС-гаас зээл олгох, зээлийн хүүг нөхөн төлөх журмын 4.3<sup>9</sup>-т заасны дагуу банк, ББСБ зээлдэгчийн барьцаа хөрөнгөөс шалтгаалан дунджаар аймаг, нийслэлд 3.0-5.0 сая, суманд 0.3-1.0 сая хүртэл төгрөгийн зээл олгож байгаа нь ажлын байр нэмэгдүүлэх боломжгүй, ихэнх зээлийг бизнес эрхэлж байгаа иргэнд олгодгоос шинээр ажлын байр нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж байна. Тухайлбал:

- Төв аймгийн 27 сумын 400 гаруй зээлдэгчдээс асуулга авахад 198 нь зээлийн доод хэмжээ 5.0 саяас дээш төгрөг байвал шинээр ажлын байр бий болгох нөхцөл бүрдэнэ гэж хариулжээ.
- Дорноговь аймагт нийт 59.9 сая төгрөгийн зээлийг 1-3 сарын хугацаатай нэг зээлдэгчид 150.0-600.0 мянган төгрөгийн хэмжээтэй олгосон ба тус аймгийн зарим сумдад олгож байгаа зээлийн дийлэнх хувийг төрийн албан хаагчдад олгосон байна. ХХҮХ-ийн банктай байгуулсан гэрээгээр нэг сая төгрөгт нэг ажлын байр бий болгох гэж заасан боловч зээлийн дүн бага байгаагаас ажлын байр нэмэгдүүлэх боломжгүй байна.
- Орхон аймагт 1.0 сая төгрөгийн зээл авч ажлын байр нэмэгдүүлэх боломжгүй байгаа талаар тайланд тусгагдсан байна.
- Хөвсгөл аймагт 2007-2009 онд нийт 1 704 зээлдэгчийн 49.0-50.0 хувь 500.0 мянган төгрөгөөс доош зээл авсан бөгөөд энэ эх үүсвэрээр 12 сарын дотор байнгын ажлын байр бий болгож ажиллах боломжгүй байна.
- Мөн тус аймагт 2007-2009 онд ХХҮХ-ийн мэргэжилтэн Н.Болормаа, Л.Лхамсүрэн нар банкинд зээлдэгч нарын тодорхойлолт гаргах, гурвалсан гэрээ хийх үйлчилгээ үзүүлэхээс өөр зээлийн хэрэгжилтэд хяналт тавиагүй байна.

2.54 НХХЯ 2007 оны 2/1346 дугаар албан бичгээр ХЭДС-гаас оюутнуудад бие даан бизнес эрхэлж, ажлын байр нэмэгдүүлэхэд зориулан “Оюутны зээл” олгох банкныг хязгаарлагдмал тендер зарлан шалгаруулах тухай үүрэг өгсний дагуу Хас банкаар дамжуулан 200.0 сая төгрөгийн “Оюутны зээл”-ийг олгож, ХЭДТХуулийн 10.1, ТБОНӨХБАҮХАТХуулийн 32.1<sup>10</sup> дүгээр заалтыг тус тус зөрчжээ.

### **Ажилгүйчүүдийн судалгаа бодитой бус байна**

2.55 2007-2009 онуудад ХХҮГ банк, ББСБ-уудтай нийт 39 880 ажлын байр шинээр бий болгохоор зээлийн гэрээ байгуулсан боловч банк, ББСБ-ын зээлийн мэдээгээр нийт 49 721 иргэд ажлын байраар хангагдсан гэж тодорхойлжээ. ҮСХ-оос гаргасан судалгаанаас үзэхэд,

Үзүүлэлт/Он	(хүнээр)		
	2007	2008	2009
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо	29 945	29 813	38 077

<sup>9</sup> Мөн тус хуулийн 4.3-т “эцсийн зээлдэгчид зээлийг нэг жил хүртэл хугацаагаар олгох бөгөөд түүний дээд хэмжээ нь 10.0 сая төгрөг хүртэл байна”

<sup>10</sup> ТБОНӨХБАҮХАТХ-ийн 32 дугаар зүйлийн 1-д Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргыг дараахь тохиолдолд хэрэглэнэ. Үүнд:

-Мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, техник, технологи шаардсан нарийн төвөгтэй бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх чадвартай этгээдийн тоо хязгаарлагдмал  
2.ТБОНӨХБАҮХАТХ-ийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах

2.56 Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2008 оныг 2007 онтой харьцуулахад 132 хүнээр багасч, 2009 оныг 2008 онтой харьцуулахад 8 264 хүнээр нэмэгдсэн байна.

2.57 ҮСХ-оос гаргасан бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо ХХҮГ-ын ажлын байраар хангагдсан ажилгүйчүүдийн тооноос зөрүүтэй байна.

2.58 Энэ нь ХХҮГ ажлын байраар хангагдсан ажилгүйчүүдийн тоог банк, ББСБ-ын зээлийн мэдээг үндэслэн гаргаж байгаатай холбоотой байна.

2.59 Графикаас үзэхэд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын тоо 2008 онд 2007 оноос 143.3 мянган хүнээр нэмэгдсэн бол 2009 онд 2008 оноос 148.5 мянган хүнээр багасжээ.



- Орхон аймагт 2009 онд арилжааны банкуудаар дамжуулан олгосон 85 зээлдэгчийн материалыг шалгаж, шинээр бий болсон ажлын байрыг судлахад 324 иргэн ажлын байртай болж, ажилгүйдэл мөн дүнгээр буурахаар байсан боловч ажлын байр нэмэгдсэн эсэхийг НД-ын хэлтэст шимтгэл төлсөн байдлаар тулган шалгахад нэмэгдээгүй байна.

2.60 Улсын хэмжээнд ажлын байранд зуучлагдсан хүн, ажилгүй иргэн, ажил идэвхтэй хайж байгаа иргэн, шинээр бий болсон ажлын байрны тоо, зээл авсан хүний тоо бодитой бус байгаа нь мэдээ, судалгаа гаргах нэгдсэн аргачлал шаардлагатайг харуулж байна.

2.61 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн аудитаар 213.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгч, 206.1 сая төгрөгийн төлбөрийг барагдуулахаар акт тогтоолоо. Аудитын явцад 148.8 сая төгрөгийн зөрчил, төлбөр барагджээ.  
(Хавсралт № 4)



## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

- ✚ Гадаадын ажиллах хүчинд хөдөлмөр эрхлэх болон ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх зөвшөөрөл өгөхдөө зохих хууль, тогтоомжийг баримтлаагүй, бүртгэл мэдээлэл дутуу, хяналт сул байгаагаас орлого дутуу төвлөрсөн байна.
- ✚ Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн оруулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд ажиллах хүчний ажлын байрны төлбөрөөс элдэв арга замаар зайлсхийж байгаагийн зэрэгцээ чөлөөлөх арга хэмжээг бизнес болгох хандлага ажиглагдаж байна.
- ✚ Гадаадаас ажиллах хүч авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх Засгийн газрын шийдвэр хугацаа оройтож гардгаас Засгийн газар, олон улсын байгууллагын хоорондын гэрээний үндсэн дээр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй саатахад нөлөөлж байна.
- ✚ ХЭДС-гийн хөрөнгийн зарцуулалтад тавих явцын хяналт хангалтгүй, зохион байгуулж байгаа арга хэмжээ, хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр нь богино хугацааны, түр зуурын шинж чанартай, үйлдвэрлэл дээрх сургалт, эрхийн бичгийн сургалт болон богино хэмжээний сургалт, нийтийн хамарсан ажлын хүрээнд ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа боловч үр нөлөө бага байна.
- ✚ Жил бүр 50.0 мянга орчим хүнийг ажилд зуучилж байгаа боловч ажилгүйдлийн түвшин бодитой буураагүй байна.
- ✚ Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтлаагүй байна.
- ✚ Банк, ББСБ зээлийн эргэн төлөлт баталгаатай байх шалгуурыг тэргүүн зэрэгт тавьдагаас зээл авахыг хүссэн боловч барьцаа хөрөнгөгүй, ажилгүй, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгч, зарим иргэдэд зээл олгогдохгүй байна.
- ✚ ҮСХ болон ХХҮГ-аас гаргаж байгаа ажилгүйчүүдийн судалгаа, тоо мэдээ зөрүүтэй, хоорондоо уялдахгүй байна.
- ✚ ХХҮГ-аас хийж байгаа ажлыг дүгнэх, үр дүнг дээшлүүлэх оновчтой арга хэмжээ үгүйлэгдэж байна.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ  
Б.БАТБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН  
ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5,  
утас: 26-15-53, факс: 32-86-34, E-mail: Mswl@mongolnet.mn

2010.07.1 № 2/1594  
танай 2010.06.21 -ны № 531 -т

Дүгнэлтийн төсөлд өгөх тайлбар, санал

Танай байгууллагаас гаргасан дүгнэлтийг судлан үзээд ажиллах хүч гадаадаас авах асуудалтай холбогдуулан дараах тайлбар, саналыг хүргүүлж байна.

Тайлбар 1-ийг  
үзнэ үү.

1. "Гадаадын ажиллах хүчинд хөдөлмөр эрхлэх болон ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх зөвшөөрөл өгөхдөө зохих хууль, тогтоомжийг баримтлаагүй, бүртгэл мэдээлэл дутуу, хяналт сул байгаагаас орлого дутуу төвлөрсөн байна" гэсэн дүгнэлтийн тухайд:

Гадаадаас авах ажиллах хүчинд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн асуудал нь өнөөдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн бөгөөд харин холбогдох хууль, тогтоомжийг шинэчлэх шаардлагатай байсан. Иймд зохих хууль, тогтоомжийг баримтлаагүй гэсэн дүгнэлтээ эргэж харахыг хүсч байна. Өөрөөр хэлбэл "Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай" хуулийн хүрээнд ажиллах хүчийг оруулж холбогдох ажилчдыг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн. Өмнөх жилүүдэд Монгол Улсын олон улсын гэрээ, Засгийн газар хоорондын гэрээгээр байгууллага, аж ахуйн нэгжүүдэд авч буй ажиллах хүчийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн байна. Мөн "томоохон төсөл, хөтөлбөр, барилга байгууламж"-ийн ажлыг гүйцэтгэж буй ажиллах хүчийг чөлөөлсөн байна.

"Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай" хууль нь 2001 онд батлагдсан, ажиллах хүчийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх болсон тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал өөр байсан тул хууль эрх зүйн орчинг шинэчлэх зайлшгүй шаардлага байгаа бөгөөд тус яам "Монгол Улсын иргэдийг гадаадад, гадаадын иргэдийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх тухай" хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-д өргөн барьсан. Уг хууль батлагдсанаар гадаадаас авах ажиллах хүчний тоо хэмжээг бууруулах, Монгол иргэдийг дотооддоо ажлын байраар хангах болон ажлын байрны төлбөрийн асуудлыг нэг мөр цэгцлэх юм.

Хууль эрх зүйн орчин тийм ч таатай бус байгаа өнөөгийн нөхцөл байдлаас улбаалан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн эрхэлж буй үйл ажиллагааг "томоохон төсөл, хөтөлбөр" мэтээр тайлбарлаж, барилгын олон аж ахуйн нэгж, компаниуд ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдөх хүсэлт тавьж чөлөөлүүлж байсан нь барилга, уул уурхайн салбарт үндэсний мэргэжилтэй ажилчин бэлтгэх замаар гадаадаас авах ажилтны тоо хэмжээг бууруулах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид Монгол ажилчдыг түлхүү ажиллуулах талаарх Засгийн газрын бодлоготой уялдахгүй байгаа, мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан орлогын эх үүсвэрээр гачигдахад хүрч байна.

БХЗГ /My doc tom blank/

Дээрх нөхцөл байдлуудыг авч үзээд Монгол Улсын Засгийн газрын 2001 онд 139 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-д өөрчлөлт орууллаа. Журмын заалтаас “Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр, барилга байгууламж” гэсэн заалтыг хассан бөгөөд үүний үр дүнд томоохон төсөл хөтөлбөр гэдэг нэрийн дор ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдөж байсан аж ахуйн нэгж компаниуд ажлын байрны төлбөрөө 2010 онд төлж байна.

Дээрх аж ахуйн нэгж компанийн чөлөөлүүлсэн төлбөр нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрч иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах үйлчилгээ, арга хэмжээнд зарцуулагдах юм.

Өмнөх онуудад ажиллах хүч гадаадаас авсан болон ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн асуудлыг **хууль, журмын дагуу шийдвэрлэж ирсэн тухай зарим тайлбарыг хүргүүлж байна.** Үүнд:

2001 онд батлагдсан “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын нийт ажиллагчдын тоо, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан нийт ажиллагчдын тоонд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг жил бүр тогтоож, Засгийн газраар батлуулах” гэж заасан байдаг. Дээрх заалтын дагуу Монгол Улсын Засгийн газар тухайн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах гадаадын ажиллагсдын хувь хэмжээг эдийн засгийн салбарын ангилал тус бүрээр баталдаг.

Засгийн газраас тогтоосон энэхүү хувь хэмжээг аж ахуйн нэгж, байгууллага баримталж ажиллах үүрэгтэй бөгөөд дээрх хувь хэмжээний дагуу гадаадаас авч буй ажиллах хүчинд зохих зөвшөөрлийг олгох, ажлын байрны төлбөрийг нь тогтоосон хэмжээний дагуу төлүүлэх үүргийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хариуцан гүйцэтгэж байна.

Харин хуулийн 7.3-т “Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга, байгууламж барих, байгалийн гамшиг, сүйрлийн хор хөнөөлийг арилгахад шаардагдах ажиллах хүчийг дотоодоос хангах бололцоогүй нөхцөлд Засгийн газрын шийдвэрийг үндэслэн гадаадаас ажиллах хүч авч болно. Өмнөх жилүүдэд Засгийн газрын шийдвэрээр оруулж ирсэн ажиллах хүч нь дээрх заалтад үндэслэсэн юм.

“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн 9.6-д “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журмыг Засгийн газар тогтооно” гэж заасан байна. Уг заалтын дагуу Засгийн газар 2001 оны 139 дүгээр тогтоолоор баталсан журамд “Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга, байгууламж барих, байгалийн гамшиг, сүйрлийн хор хөнөөлийг арилгахад шаардагдах ажиллах хүч, мэргэжилтнийг Засгийн газрын шийдвэрийн дагуу гадаадаас авч ажиллуулах тохиолдолд ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө” гэж заасны дагуу салбарын яамд тухайлбал, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамдын саналыг үндэслэн тус яам Засгийн газарт асуудлыг боловсруулан оруулсан болно.

Мөн түүнчлэн “Улсын хэмжээний томоохон төсөл хөтөлбөр...” гэдэг нь ойлгомжгүй, асуудлыг хэт хавтгайруулах байдалд хүргэж болзошгүйг тус яам анхааран үзээд Монгол Улсын Дээд шүүхэд тайлбар гаргуулахаар хандсан юм. Монгол Улсын Дээд шүүхээс ирүүлсэн 2008 оны 4/2183 дугаар албан тоотод “...хуулийн заалтын талаар “томоохон төсөл, хөтөлбөр” гэдгийг хэрхэн ойлгох талаар ямар нэг маргаан

БХЗГ, /My doc:tom blank/

## Тайлбар 2-ыг үзнэ үү.

гараагүй, хоёрдмол утга агуулаагүй тул Улсын Дээд шүүхээс албан ёсны тайлбар гаргах шаардлагагүй гэж үзсэнийг мэдэгдье” гэсэн хариуг ирүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2009 оны орлогын төлөвлөгөөг төлөвлөхдөө 2008 оны гүйцэтгэл дээр үндэслэсэн гэсэн тайлбарыг ХХҮГ хийж байна. 2008 онд барилгын ажил өргөн далайцтай өрнөсөнтэй холбогдон гадаадаас орж ирэх ажилчдын тоо нэмэгдсэн байна. Харин 2009 онд бий болсон эдийн засийн хямралын нөлөөгөөр зам, барилгын ажил буурч, ажилчдын эрэлт багассан нь бас нэг нөлөөлөлх хүчин зүйл болсон байна.

ХЭДС-ийн орлого нь одоогоор гадаадаас орж ирж буй ажиллах хүчний ажлын байрны төлбөрөөс бүрдэж байгаа тул орлогын хэмжээг нэмэгдүүлэх асуудал нь гадаадаас авах ажиллах хүчний тоог бууруулах бодлоготой уялдахгүй байгаа тул орлогын төлөвлөгөө биелүүлэх асуудлыг болгоомжтой авч үзэх шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, гадаадаас олон хүн оруулж ирж байж орлогын төлөвлөгөө биелэх нөхцөл байдал үүсч байгааг хаа хаанаа анхааран үзэх хэрэгтэй юм.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан, судлан үзэж, дүгнэлтийн төслөө эцэслэн боловсруулна гэдэгт итгэлтэй байна.

Бидэнтэй хамтран ажиллаж буй та бүхэнд баярлалаа.

ДЭД САЙД  Д.НЯМХҮҮ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Хувьсгалчдын гудамж 14, Утас: 26-02-19,  
Факс: (976-11) 32-79-06, E-mail: ceo@mongolnet.mn*2010.08.28* № *7/1028*

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тайлангийн төсөлд зарим  
тайлбар гаргах тухай

Тус газарт ирүүлсэн Үндэсний аудитын газраас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнгийн талаар хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараахь тайлбарыг гаргаж байна. Үүнд:

**Тайлбар 3-ыг  
үзнэ үү.**

1. 2.44-т "ТБОНӨХБАҮХАТХуулийн 45.2.2-ын 6 дахь заалтыг зөрчин НХХЯ 2007-2009 онд 26980,0 сая төгрөгийн жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэх банк, ББСБ-ыг сонгох сонгон шалгаруулалтыг явуулаагүй учраас ХХҮГ дээрх сонгон шалгаруулалтыг гүйцэтгэсэн байна" гэжээ.

ХЭДС-аас банк, ББСБ-аар дамжуулан ажлын байр бий болгох зорилготой зээлийг 2004 оноос өмнө Хөдөлмөр эрхлэлтийн газар тухайн банк, ББСБ-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулах замаар олгож ирсэн байдаг. Харин 2005 оны 07 дугаар сарын 05-нд Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга Ч.Хүрэлбаатар даргатай Тендерийн хороо 2005 онд тус сангаас жижиг зээл олгох үйл ажиллагааг Монгол шуудан, Анод банкуудаар дамжуулан олгохоор шийдвэрлэж тус бүр 500,0 сая төгрөгийг байршуулсан юм. Гэтэл 2005 оны 12 дугаар сард ТБОНӨХБАҮХАТХууль шинэчлэн батлагдсан тул НХХ-ийн дэд сайд С.Чинзориг яг дээрх зээлийн гэрээ дуусгавар болох үед буюу 2006 оны 07 дугаар сард цаашид тендерийг НХХЯ, агентлагийн аль нь зохион байгуулах тухай Сангийн яамнаас тодруулга хүсчээ.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Хүрэлбаатар 2006 оны 07 дугаар сарын 05-нд ирүүлсэн зөвлөмждөө "ТБОНӨХБАҮХАТХуулийн 45.1, 46.2 дугаар заалтын дагуу төсвийн хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх худалдан авах ажиллагааны хувьд тухайн асуудал хариуцсан байгууллага нь захиалагчийн эрх үүргийг хэрэгжүүлнэ... Захиалагч байгууллагын даргын шийдвэрээр байгуулах Үнэлгээний хороонд уг санд хяналт тавих эрх үүргээ хэрэгжүүлэх зорилгоор яамнаас төлөөлөл оруулах нь зүйтэй" гэсэн байх тул НХХЯ-

004504

## Тайлбар 4-ийг үзнэ үү.

ны зөвшөөрснөөр цаашид ХХҮГ-ын даргын тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд НХХЯ-наас төлөөллийг тогтмол оролцуулж ирсэн юм.

2009 оноос уг тендерийн арга хэмжээг НХХЯ-наас зохион байгуулж байна.

2.46-д “Түүнчлэн банкнаас ирүүлсэн зээлийн үнийн саналыг нийт 1900,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн гэрээ байгуулжээ” гэжээ.

ХХҮГ нь ХЭДС-аас олгох жижиг зээлийн эх үүсвэрийг жил бүр төсөвтөө тусгаж ирсэн бөгөөд харин урьд онуудад банкинд байршуулсан зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийг сангийн төсвийн орлогын төлөвлөгөөнд тусгагддаггүй учраас тендерийн шаардлага хангасан банк, ББСБ-д үргэлжлүүлэн байршуулж ирсэн болно.

Тухайлбал, жижиг зээлийн эх үүсвэрийг ХЭДС-аас 2006 онд зээлийн зориулалтаар нэмж байршуулахаар батлагдсан төсвийн 1620,0 сая төгрөг, зээлээс эргүүлэн татсан 2540,0 сая төгрөг, үүнээс 4010,0 сая төгрөг байршуулсан нь төлөвлөгөөнөөс 150,0 сая төгрөгөөр дутуу, 2007 онд зээлийн зориулалтаар нэмж байршуулахаар батлагдсан төсвийн 5770,0 сая төгрөг, зээлээс эргүүлэн татсан 4010,0 сая төгрөг, нийт 9780,0 сая төгрөг, 2008 онд зээлийн зориулалтаар нэмж байршуулахаар батлагдсан төсвийн 8400,0 сая төгрөг, зээлээс эргүүлэн татсан 7780,0 сая төгрөг, үүнээс 16150,0 сая төгрөг байршуулсан нь төлөвлөгөөнөөс 30,0 сая төгрөгөөр дутуу байна. Харин 2009 онд зээлийн зориулалтаар нэмж байршуулахаар батлагдсан төсвийн 9900,0 сая төгрөг, зээлээс эргүүлэн татсан 9000,0 сая төгрөг, нийт 18900,0 сая төгрөг байхаар байсан боловч зөвхөн 9050,0 сая төгрөгийг байршуулж, үлдсэн эх үүсвэрийг ХЭДС-ийн төсөвт тодотгол хийж нийтийг хамарсан ажилд шилжүүлэн зарцуулсан болно. Иймд Үнэлгээний хороо тухайн жилийн ХЭДС-ийн төсөвт тусгасан эх үүсвэрийн хүрээнд тендерийг зарлаж, зээлийн өмнөх үлдэгдэл дээр нь нэмж байршуулах замаар шийдвэрлэж ирлээ.

## Тайлбар 5-ыг үзнэ үү.

2. 2.47-д “ ХХҮГ-ын 2007 оны тендерийн бичиг баримтад зээлийн хүүг 1,5 хувиас ихгүй байна гэж заасан боловч үнэлгээний хороо 1,9 хувийн хүүтэй зээлийн үйл ажиллагаа явуулах санал өгсөн Анод банкыг шалгаруулжээ” гэжээ.

ХХҮГ-ын даргын 2007 оны 06 дугаар сарын 22-ны 77 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 2007 оны 08 дугаар сарын 07-ны өдөр тендер шалгаруулалтыг явуулж, Хаан, Монгол шуудан, Капитал, Анод банкинд тус бүр 500,0 сая, Хас банкинд 300,0 сая төгрөгийн эх үүсвэрийг байршуулахаар шалгаруулжээ. Тус тендер оролцогч Анод банк нь тендерийн бүхий л шалгуурыг хангаж байсан бөгөөд тендерийн бичиг баримтад ирүүлсэн бизнес төлөвлөгөөндөө 500,0 сая төгрөгийг 1,5 хувийн хүүтэйгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийг хэрэгжүүлэхээр үнийн санал ирүүлсэн байх тул 500,0

сая төгрөгийг 1 жилийн хугацаатай байршуулж, 1,5 хувийн хүүтэйгээр дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулсан юм.

Холбогдох тайлбар, үндэслэлүүдийг харгалзан үзэж тайлангийн төсөлд зааруулга хийхийг хүсэж байна. Манай ажилд гүйцэтгэлийн аудитын дүгнэлт хийж, цаашид анхаарах асуудлаар үнэтэй санал зөвлөмж гаргаж хамтран ажилласан аудиторын багт талархал илэрхийлье.

Жич: ХХҮГ, Анод банк хоорондын ХЭДС-аас жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэх 2007 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 11 дүгээр гэрээ /3 хуудас/, ХЭДС-аас жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэх банкыг сонгон шалгаруулах тендер ХЭДС/2007/07 хавтаст хэрэг дэх Анод банкны Бизнес төлөвлөгөөний 7,11 дүгээр хуудаснуудын хуулбар, ХЭДС-аас жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэх банкыг сонгон шалгаруулах тендер ХЭДС/2007/07 хавтаст хэрэг дэх 216 дугаар хуудас дахь Тендерийн нээлтийн тэмдэглэл, үнийн саналуудын хуулбар, 219,220 дугаар хуудас дахь Тендер шалгаруулалтын Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийн хуулбарыг тус тус хавсаргав.



Д.БАЯРСАЙХАН

## Тайлбар:

Тайлбар 1	АХГГГАХМАХТХуулийн 7.2.4, 8.2.2, 8.2.6-д заасан нөхцөл, Засгийн газрын 2009 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувь хэмжээг харгалзаагүй нь баримтаар нотлогдож байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 2	Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуулиар ХХҮГ-т гадаад иргэдийн ажлын байрны төлбөрт 25000.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө баталж, гүйцэтгэлээр 12 682.4 сая төгрөг төвлөрчээ.Цаашид орлогыг үндэслэлтэй төлөвлөх нь зүйтэй гэж үзсэн болно.
Тайлбар 3	ТБОНӨХБАҮХАТХуулийн 45.2.2-т заасны дагуу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам тендерийн сонгон шалгаруулалт явуулах ёстой байна. Найруулгын засвар хийлээ.
Тайлбар 4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас банк, банк бус санхүүгийн байгууллагад байршуулах зээлийн эх үүсвэрийг НХХС-ын баталсан төлөвлөгөөний дагуу 1 900.0 сая төгрөгөөр нэмж гэрээ байгуулжээ гэж өөрчиллөө.
Тайлбар 5	Саналыг хүлээн авлаа.



## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

### **Нэг. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид:**

- ✚ Гадаад ажиллах хүч, мэргэжилтэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх асуудлыг тухайн оны 2 дугаар сард багтаан шийдвэрлүүлж байх;
- ✚ ХХҮГ-ын ажлыг цаашид бодит үр дүнгээр дүгнэж, хариуцлага тооцож ажиллах.

### **Хоёр. Уул уурхай, зам барилгын салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх үйлдвэрлэл дээрх сургалтын туршилтын дэд хөтөлбөрийн зохицуулах зөвлөлийн дарга, НХХЯ-ны дэд сайд Д.Нямхүүд:**

- ✚ Үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэргэжлийн арга зүйгээр хангаж, төгсөгчдөөс авах шалгалтын тестийг боловсруулан, 2009 онд сургалт явуулсан аж ахуйн нэгжийн гэрээг дүгнэж, тайлагнах.

### **Гурав. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Баярсайханд**

- ✚ Мэргэжлийн сургалт, ажлын байр, гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт, ажил зуучлалын талаар мэдээллийн нэгдсэн сантай болох;
- ✚ Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан иргэдийн бүртгэл, мэдээллийг ГИХАЭГ- тай тулган баталгаажуулж, ажлын байрны төлбөрийг бүрэн төлүүлж байх;
- ✚ ХЭДС-гийн хөрөнгийг аль болох далайцтай бүтээн байгуулалтын ажилд чиглүүлж, ажилгүй иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, тогтвортой ажлын байраар хангах нөхцөл боломжийг судлаж шийдвэрлэх;
- ✚ Ажил олгогч нарт зайлшгүй шаардлагатай байгаа мэргэжил олгох сургалтын чанарыг сайжруулах, явцад хяналт тавих, сургалтын төвүүдийг аттестатчлах;
- ✚ Бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон сургалтын төвийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримталж ажиллах;
- ✚ Зээл олголт, зээлийн мэдээнд дүн шинжилгээ хийх замаар ажлын байраар тогтвортой хангаж, ажилгүйдэл бууруулах бодлого бодитой хэрэгжиж буй эсэхийг тооцож, цаашид жил бүр боловсронгуй болгон шинэчилж байх;
- ✚ Илэрсэн зөрчил, дутагдалд холбогдох хүмүүст хариуцлага тооцох.

## Хавсралт №1

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах зөвшөөрөл болон ажлын байрны төлбөрөөс зохих хууль, журам зөрчин чөлөөлөгдсөн зарим аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа

(сая төгрөгөөр)

№	Аж ахуйн нэгжийн нэр	Улсын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Засгийн газрын тогтоол			Гүйцэтгэл		мөрдөж буй квот	Зөрүү	хугацаа (сараар)	Аудитаар илрүүлсэн зөрчил
				дугаар	ХЭ зөвшөөрөл олгосон хүний тоо	АБТ-с чөлөөлсөн хүний тоо	ХЭ зөвшөөрлөөр орж ирсэн хүний тоо	АБТ-өөс чөлөөлөгдсөн хүний тоо				
1	"Их үйлсийн эрэлд" ХХК	Монгол-БНХАУ	100 мянган айлын орон сууц хөтөлбөр	102	900	900	779	779	291	488	7	737.9
2	"Богда холдинг"ХХК	Монгол-БНХАУ	100 мянган айлын орон сууц хөтөлбөр	123	400	200	246	200	90	110	5	118.8
3	"Гандирс" ХХК	Монгол	100 мянган айлын орон сууц хөтөлбөр	102	150	150	89	89	40	49	6	63.5
4	"Задран" ХХК	БНХАУ	100 мянган айлын орон сууц хөтөлбөр	158	500	250	58	58	26	32	4	10
5	"Зунбоо"ХХК	БНХАУ	100 мянган айлын орон сууц хөтөлбөр	123	300	150	201	150	80	70	5	75.6
6	"Иншипин" ХХК	БНХАУ	100 мянган айлын орон сууц хөтөлбөр	158	80	40	77	40	15	25	4	21.6
7	"Аззунхуй" ХХК	Монгол-БНХАУ	100 мянган айлын орон сууц хөтөлбөр	158	200	100	119	100	30	70	1	15.1
8	"Нар Урт"ХХК	Монгол	100 мянган айлын орон сууц хөтөлбөр	102	345	345	124	124	46	78	3	50.5
9	"Насны зам"ХХК	Монгол-БНХАУ	Эрдэнэт-Булган-Уньтын 146 км хатуу хучилттай зам	102, 228	340	340	229	229	139	90	5	97.2
10	"Хэм роял" ХХК	Монгол	100 мянган айлын орон сууц хөтөлбөр	123	400	250	253	250	84	166	6	215.1
11	"Шинэ дөл" ХХК	Монгол	40 мянган айлын орон сууц хөтөлбөр	102	150	150	150	150	52	98	7	148.2
<b>НИЙТ ДҮН</b>					<b>3765</b>	<b>2875</b>	<b>2325</b>	<b>2169</b>	<b>893</b>	<b>1276</b>		<b>1553.5</b>

## Эх үүсвэрийг нэмж байгуулсан гэрээнүүд

№	Банкны нэр	Гэрээ байгуулсан хугацаа	Гэрээний дүн (сая.төг)	Банкны тендерийн баримт бичиг дээрх зээлийн үнийн санал (сая.төг)	Зөрүү (сая.төг)	ХХҮГ-ын даргын тушаал
1.	Монгол Шуудан банк	2007.09.24 2008.09.24	1500,0	500,0	1000,0	ХХҮГ-ын даргын 2007 оны 9 дүгээр сарын 104 дүгээр тушаал
2.	Капитал банк	2007.12.20 2009.05.20	500,0	400,0	100,0	ХХҮГ-ын даргын 2007 оны 12 дугаар сарын 144 дүгээр тушаал
3.	Хаан банк	2008.05.19 2009.11.19	2600,0	2500,0	100,0	ХХҮГ-ын даргын 2008 оны 5 дугаар сарын 46 дугаар тушаал
4.	Монгол Шуудан банк	2008.05.19 2009.11.19	2600,0	2500,0	100,0	ХХҮГ-ын даргын 2008 оны 5 дугаар сарын 46 дугаар тушаал
5.	Хас банк	2008.05.19 2009.11.19	600,0	300,0	300,0	ХХҮГ-ын даргын 2008 оны 5 дугаар сарын 46 дугаар тушаал
6.	Анод банк	2008.09.01 2010.03.01	800,0	500,0	300,0	ХХҮГ-ын даргын 2008 оны 8 дугаар сарын 79 дугаар тушаал
<b>Дүн</b>			<b>8600,0</b>	<b>6700,0</b>	<b>1900,0</b>	

## 2007-2009 ОНД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

№	Аймгийн ХХҮХ	ХААН банк	Аудитаар	Зөрүү	МШБ	Аудитаар	Зөрүү	Капитал банк	Аудитаар	Зөрүү	ХАС банк	Аудитаар	Зөрүү	Нийт зөрүү
1	Архангай	545156.0	547556.0	-2400.0	516442.0	516442.0	0.0	464100.0	444600.0	19500.0	31300.0	34300.0	-3000.0	14100.0
2	Говь-Алтай	500973.6	540007.6	-39034.0	477526.0	508511.0	-30985.0	0.0	0.0	0.0	50159.0	53859.0	-3700.0	-73719.0
4	Дорноговь	455527.0	447077.0	8450.0	444370.0	387170.0	57200.0	168219.6	169237.6	-1018.0	8000.0	8000.0	0.0	64632.0
5	Дорнод	341965.2	341965.2	0.0	356611.0	350755.0	5856.0	0.0	0.0	0.0	34728.0	34728.0	0.0	5856.0
6	Өмнөговь	571430.0	565730.0	5700.0	424250.0	423050.0	1200.0	246200.0	246200.0	0.0	12400.0	12400.0	0.0	6900.0
7	Сүхбаатар	617220.0	608980.0	8240.0	304468.0	329779.0	-25311.0	0.0	0.0	0.0	21100.0	24300.0	-3200.0	-20271.0
8	Төв	581871.2	553671.2	28200.0	485795.0	393830.0	91965.0	8000.0	0.0	8000.0	13000.0	12000.0	1000.0	129165.0
9	Ховд	565032.1	565032.1	0.0	417470.0	417470.0	0.0	0.0	0.0	0.0	28320.0	30620.0	-2300.0	-2300.0
10	Хөвсгөл	736734.0	648985.6	87748.4	432640.0	494826.4	-62186.4	844900.0	845900.0	-1000.0	68875.8	72460.0	-3584.2	20977.8
11	Дархан	271664.0	157888.4	113775.6	506560.0	505731.8	828.2	332800.0	310100.0	22700.0	25475.0	25475.0	0.0	137304.0
12	Уул													
13	Орхон	190600.0	144600.0	46000.0	280300.0	261800.0	18500.0	217700.0	145100.0	72600.0	61600.0	35800.0	25800.0	162900
14	Говьсүмбэр	43550.0	53050.0	-9500.0	249730.0	200650.0	49080.0	0.0	0.00	0.0	200.0	0.0	200.0	39780.0
15	Дундговь	353650.0	353650.0	0.0	369981.1	376981.1	-7000.0	0.0	0.0	0.0	43300.0	18300.0	25000.0	18000.0
	Нийт дүн	5775373.1	5528193.1	247180.0	5266143.1	5166996.3	99146.8	2281919.6	2161137.6	120782.0	398457.8	362242.0	36215.8	503324.8

**Жич:Анод банк аудитад хамрагдаагүй болно.**

(Хавсралт №4)

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн аудитаар илэрсэн зөрчил дутагдал

10.06.14

(мянган төгрөгөөр)

№	Аймаг	Нийт зөрчил, дутагдал	Үүнээс		Тайлбар
			Албан шаардлага	Акт	
1	Архангай	34664.8	28310.4	6354.4	26462,3 барагдсан
2	Баян-Өлгий	34295.0	30555.0	3740.0	
3	Баянхонгор	37937.5	27668.0	10269.5	27668.0 мянган төгрөг аудитын явцад барагдсан
4	Булган	12310.0	5446.0	6864.0	1406.3 мянган төгрөг барагдсан
5	Говь-Алтай	1000.0	1000.0		
6	Дорноговь	0	0	0	
7	Дорнод	748.6	0	748.6	
8	Дундговь	26952.5	26952.5	0	
9	Завхан	5290.9	5002.9	288.0	
10	Өвөрхангай	26028.1	20813.0	5215.1	
11	Өмнөговь	0	0	0	
12	Сүхбаатар	0	0	0	
13	Сэлэнгэ	8614.1	3464.0	5150.1	
14	Төв	1070.0	0	1070.0	
15	Увс	20342.9	2000.0	18342.9	
16	Ховд	31807.0	25464.3	6342.7	
17	Хөвсгөл	0	0	0	
18	Хэнтий	45558.2	20953.9	24604.3	
19	Дархан-Уул	130.3	0	130.3	
20	Орхон	3909.5	1594.5	2315.0	
21	Говьсүмбэр	32495.9	14138.3	18357.6	
22	ХХҮГ	96289.0		96289.0	Аудитын явцад 96289.0 мянган төгрөг барагдсан.
<b>Нийт дүн</b>		<b>419444.3</b>	<b>213362.8</b>	<b>206081.5</b>	

Гүйцэтгэлийн аудитын газар



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2010 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

**Аудитын тайланг баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.


Хоёр. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөрийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Аудитын тайланг Улсын Их Хурлын Эдийн Засгийн Байнгын хорооны дарга Ц.Баярсайхан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Баярсайхан нарт хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2010 оны 12 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Баярсайханд зөвлөсүгэй.

Тав. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

070147  
Төсөлд

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2010 оны 6.7 дугаар тушаалын хавсралт  
**Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөрийн жагсаалт**

№	Төлбөр, зөрчил хармууцагчийн		Төлбөр зөрчлийн товч утга	Төлбөр тогтоосон аудитор, шинжээчийн нэр	Актны дугаар	Төлбөрийн дүн	Аудитын явцад барагдуулсан	
	нэр	албан тушаал						
1	Д.Баярсайхан Б.Амаржаргал	ХХҮГ-ын дарга ХХҮГ-ын СХ-ийн мэргэжилтэн	Хүн амын орлогын албан татварыг төсөвт төвлөрүүлэх	Ахлах аудитор С.Сэрчхорол, шинжээч Б.Болормаа	01/62	80 000,0	80 000,0	
2	Ц.Ганхуяг	ХХҮГ-ын ГХЭХ-ийн дарга	Гадаад томилолтын зардлын зөрүү	"-"	02/63	62 184,0	62 184,0	
3	Д.Баярсайхан Д.Хишигням	ХХҮГ-ын дарга ХХҮГ-ын СХ-ийн мэргэжилтэн	Хүн амын орлогын албан татварыг төсөвт төвлөрүүлэх	"-"	03/64	542 600,0	542 600,0	
4	Ч.Эрдэнэчимэг	НХХЯ-ны ахлах мэргэжилтэн	Гадаад томилолтын зардлын зөрүү	"-"	04/65	931 840,0	931 840,0	
5	Ч.Эрдэнэчимэг	НХХЯ-ны ахлах мэргэжилтэн	Томилолтын унааны зөрүү	"-"	05/66	108 000,0	108 000,0	
6	Жан мин жун	"Задран" ХХК-ий захирал	Ажлын байрны төлбөрийг төлүүлэх	"-"	05/69	10 000 000,0	10 000 000,0	
7	Х.Идэнбаяр	"Богда холдинг" ХХК-ий ерөнхий захирал	Ажлын байрны төлбөрийг төлүүлэх тухай	"-"	04/68	2 880 000,0	2 880 000,0	
8	Тан цилие	"Голден сий петролеум" ХХК-ий ерөнхий захирал	Ажлын байрны төлбөрийг төлүүлэх тухай	"-"	06/70	1 080 000,0	1 080 000,0	
9	М.Равданжамц	"ЭНК" ХХК-ий ерөнхий захирал	Ажлын байрны төлбөрийг төлүүлэх тухай	"-"	02/66	1 080 000,0	1 080 000,0	
10	Б.Бат	"Заамарын их алт" ХХК-ий гүйцэтгэх захирал	Сургалтын төлбөр төлүүлэх тухай	Шинжээч Д.Баттулга	01/74	2 560 000,0	2 560 000,0	
11	Б.Алтанцэцэг	"Нимонс" ХХК-ий сургалтын менежер	Сургалтын төлбөр төлүүлэх тухай	"-"	02/75	2 200 000,0	2 200 000,0	
12	С.Мягмарсүрэн	"Арвис Итгэл сан" ББСБ-ын нягтлан бодогч	Зээлийн эх үүсвэр	Шинжээч Р.Цолмон	02/42	22 000 000,0	22 000 000,0	
13	С.Мягмарсүрэн	"Арвис Итгэл сан" ББСБ-ын нягтлан бодогч	Хугацаа хэтэрсэн алданги тооцох тухай	Шинжээч Р.Цолмон	02/42	937 400,0	937 400,0	
13	Б.Батбаатар	"Актив Инвест" ББСБ-ын захирал	Зээлийн эх үүсвэр	"-"	03/43	50 000 000,0	50 000 000,0	
14	Б.Дэлгэржаргал	"Хас" банк санхүү эрхэлсэн захирал	Зээлийн хугацаа хэтэрсний алданги тооцох тухай	"-"	07/47	600 000,0	600 000,0	
15	С.Энхтуяа	"Эрхэс Эрдэнэ" ББСБ захирал	Зээлийн хугацаа хэтэрсний алданги тооцох тухай	"-"	09/53	385 000,0	385 000,0	
16	З.Цэрэнгомбо	"Цэнүж" ББСБ ажилтан	Зээлийн хугацаа хэтэрсний алданги тооцох тухай	"-"	06/46	50 000,0	50 000,0	
17	З.Нарандэлгэр	"Цэцэрлэг-Ар" ББСБ ня-бо	Зээлийн хугацаа хэтэрсний алданги тооцох тухай	"-"	04/44	900 000,0	900 000,0	
	<b>НИЙТ ДҮН</b>						<b>96 397 024,0</b>	<b>96 397 024,0</b>